



Шинжээчийн тайлан

**Байгууллагын нэр: ИХ ЗАСАГ ИХ СУРГУУЛЬ, САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН
СУРГУУЛЬ**

Хөтөлбөрийн нэр: НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ

Индекс: **D041101**

Шинжээчийн баг:

Ахлагч: Н.Нямаа
Гишүүд: Л.Ариунбат
..... Ч.Өнөржаргал

2019 он 04 сар 26 өдөр

Агуулга

Товчилсон үгийн тайлбар

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс.

IV. Төгсөгчдийн нэрс

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Товчилсон үгийн тайлбар

ААН- Аж ахуйн нэгж

АГҮБ – Ажлын гүйцэтгэлийн үнэлгээний баг

ИЗОУИС- Их Засаг Олон Улсын Их Сургууль

ИЗСЭЗС – Их Засаг Санхүү Эдийн Засгийн Сургууль

МУИС – Монгол улсын их сургууль

ММНБИ- Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт

НББ – Нягтлан бодох бүртгэл

НББОУС – Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт

ОУ – Олон улс

СЭЗИС – Санхүү эдийн засгийн их сургууль

СЯ – Сангийн яам

ХААИС- Хөдөө аж ахуйн их сургууль

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	Их засаг олон улсын их сургууль, Санхүү Эдийн Засгийн Сургууль Ikh zasag international university	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	Нягтлан бодох бүртгэл Accounting	
Индекс	D041101	
Шинжээчид	Н.Нямаа /ХААИС-ийн Эдийн засаг бизнесийн сургуулийн профессор Л.Ариунбат /ОУУБИС-ийн Сургалтын албаны дарга, дэд профессор/ Ч.Өнөржаргал /СЭЗИС-ийн Олон улсын Нягтлан бодох бүртгэлийн мэргэшсэн сургуулийн ахлах багш	
БМИУЗ-ийн Мэргэжилтэн	П.Оргилмаа	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд
	2019.04.10	Мэргэжилтэн шинжээчдийн нэрсийг хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багт илгээж, ашиг сонирхлын зөрчилтэй эсэх талаар саналыг хүлээн авах
	2019.04.10	Шинжээчийн багийг томилох
	2019.04.10	Шинжээчидтэй гэрээ байгуулах
	2019.04.10	Шинжээчдэд өөрийн үнэлгээний тайланг хавсралтын хамт хүлээлгэн өгнө.
	2019.04.15	Шинжээчид тодруулах асуудлын жагсаалт гаргаж өгнө
	2019.04.17	Сургууль дээр ажиллах: Удирдлага болон өөрийн үнэлгээний багтай уулзах, Сургуулийн бэлтгэсэн материал, илрэл нотолгоотой танилцах, Сургуультай танилцах, Оюутнуудтай уулзалт хийх, Багш нартай уулзах Номын сан, лаборатори, үйлчилгээний хэсэгтэй танилцах
	2019.04.18	Сургууль дээр ажиллах: Тайлантай холбоотой нотлох баримттай танилцах, холбогдох хүмүүсээс тодруулга, лавлагаа авах, Ажил олгогчидтой уулзах, Төгсөгчидтэй уулзах, Шинжээчдийн багийн уулзалт хийх, Урьдчилсан дүгнэлтийг байгууллагад танилцуулах
	2019.04.25	Шинжээчид үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	2019.04.25	Шинжээчдийн үнэлгээний тайланг сургуульд илгээж санал авна.
	2019:04.28	Шинжээчид үнэлгээний тайланг эцэслэнэ.
	Хуваарьт хуралдаан	Мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар шинжээчийн үнэлгээний тайланг танилцуулж шийдвэрлүүлнэ.
Шалгуур шаардлага /журам/	БМИУЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 08 дугаар тогтоолоор батлагдсан “Боловсролын магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам, магадлан итгэмжлэлийн шалгуур шаардлагын дагуу ажиллав.	

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Их Засаг ОУИС нь 7 салбар сургуультай бөгөөд 2019 оны байдлаар 5700 гаруй оюутан бакалаврын хөтөлбөрөөр, 450 орчим магистрант, докторант суралцаж байна.

Их Засаг ОУИС нь 2010 онд Ази номхон далайн бүсийн чанарын сүлжээний гишүүн, 2014 онд Их Британийн Үндэсний магадлан Итгэмжлэх зөвлөлөөр олон улсад анх удаагаа, 2017 онд 2 дахь удаагаа магадлан итгэмжлэгдсэн байна. Энэ нь хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагын зорилго зорилт нь олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалж сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэгджээ.

Сургуулийн стратеги төлөвлөгөө, дунд хугацааны стратеги төлөвлөгөөг 2007, 2009 онуудад батласан бөгөөд уг төлөвлөгөөнд НББ-ийн бакалаврын сургалтыг тогтвортой, боловсролын шинэчлэлд нийцсэн сургалт явуулах, багш нарын багийг бүрдүүлж чадваржуулах бодлогыг тодорхойлсон.

НББ мэргэжлийн хөтөлбөрөөр суралцаж буй оюутан 4 жилийн хугацаанд 121 кр хичээл судална. Хөтөлбөрийн агуулгыг 2006, 2008, 2012, 2014, 2018 онуудад нийт 5 удаа шинэчилжээ. Ингэхдээ МУИС, СЭЗИС, Мандах их сургууль, ХААИС гэсэн дотоодын 4 сургууль, Гадаадын их дээд сургуулиудаас өөрийн хамтын ажиллагаатай БНСУ-ын Kyonggi university, Өвөрмонголын багшийн их сургуулийн НББ-ийн хөтөлбөртэй харьцуулсан судалгаа хийж хөтөлбөрийг сайжруулж ирсэн байна.

2000 оноос НББ мэргэжлээр элсэлт авч 2002-2003 оны хичээлийн жилээс “Эдийн засаг НББ-ийн сургууль” нэртэйгээр бүрэлдэхүүн сургууль болж 2017 оноос “Санхүү эдийн засгийн сургууль” болж нэрээ өөрчилсөн 12 удаагийн төгсөлт хийсэн.

“Их засаг судлал” хөтөлбөр, “Цогц боловсрол олгох” хөтөлбөр, ”Эх оронч үндэсний үзэл, хүмүүжил” хөтөлбөр, “Цогц боловсрол олгох хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж байна. Цогц боловсрол олгох хөтөлбөрөөр 7 чадамжийг тодорхойлжээ. Оюутны цагийн ачааллыг 7 хоногт дунджаар 18 цагийн танхимын хичээлийн ачаалалтай. Сургалтын орчин, материаллаг бааз суурилагдсан багшлах боловсон хүчнийг бүрдүүлж чадсан байна.

Ш. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

-Нийгэм, эдийн засаг, технологи, салбарын хөгжлийн ирээдүйн төлөв, сонирхогч талуудын эрэлт хэрэгцээнд хийсэн дүн шинжилгээ, ажлын төлөвлөгөө, бенчмарк, судалгааны танилцуулга /PEST, STEEP гэх мэт/

-Гадаад дотоодын хөтөлбөрүүдтэй харьцуулсан судалгаа, бенчмарк

Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийг их дээд сургуулиудын мэргэжилтэн бэлтгэх хандлага, тухайн мэргэжлээр элсэгчдийн эрэлт, хэрэгцээнд тулгуурлан боловсруулсан.
- Ижил мэргэжлээр сургалт явуулдаг их, дээд сургуулиудын багц цаг, кредит болон нэр томъёог харьцуулсан судалгааг хийж сургалтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулдаг. Дотоодын МУИС, СЭЗИС, Мандах их сургууль, ХААИС гэсэн дотоодын 4 сургуулийн НББ-ийн хөтөлбөрүүдийг харьцуулан судлаж бенчмарк хийж өөрийн онцлогт тохируулан хөтөлбөрийг боловсруулсан. Гадаадын их дээд сургуулиудаас өөрийн хамтын ажиллагаатай БНСУ-ын Kyonggi university, Өвөрмонголын багшийн их сургуулийн эдийн засгийн сургуулийн хөтөлбөртэй харьцуулсан судалгаа хийсэн.
- Төгсөгчид, дадлага хийж буй оюутнуудыг ажлын байраар хангадаг ААН, байгууллагуудаас ирүүлсэн саналыг нэгтгэж хамгийн ихээр шаардлагатай байгаа ур чадвар болох НББ-ийн программ дээр ажиллах чадварыг нэмэгдүүлэх чиглэлийг төлөвлөгөөнд тусгасан.
- “НББ-ийн олимпиадад оролцсон багийн суралцагчдын англи хэл, өөрийгөө илэрхийлэх чадвар, НББ-ийн программ, мэдээлэл боловсруулах, дүн шинжилгээ хийх, практик ур чадвар бусад сургуулийн төгсөгчдөөс дутмаг байна” гэсэн 2012, 2013, 2014, 2015 оны ажлын тайлан санал, дүгнэлтэд үндэслэн хөтөлбөрийн төлөвлөлтийг хийсэн.
- Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн үйл явц-үр дүнд суурилсан үнэлгээг сургуулийн удирдлага, багш нар хамтран хийдэг.
- Сургалтын төлөвлөгөөнд НББ-ийн мэргэжлээр 4 жилийн хугацаатай суралцаж нийтдээ 48 төрлийн 121 кредит цагийн агуулгатай хичээлийг судлахаар тусгагджээ. 2000 оноос НББ мэргэжлээр элсэлт авч 2002-2003 оны хичээлийн жилээс “Эдийн засаг НББ-ийн сургууль” нэртэйгээр бүрэлдэхүүн сургууль болж 2017 оноос “Санхүү эдийн засгийн сургууль” болж нэрээ өөрчилсөн 12 удаагийн төгсөлт хийсэн нь харьцангуй олон жилийн туршлагатай хөтөлбөр болохыг илэрхийлж байна.
- Монголын болон гадаадын төр, олон нийтийн байгууллагуудаас нийгэм, олон нийт, хүмүүнлэг, боловсрол, бизнесийн, чанарын баталгаажуулалтын гэх мэт шагнал өргөмжлөлүүдийг авч байсан нь хөтөлбөр, сургуулийн нийгэм, олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөнийг илэрхийлж байна.
- Их Засаг ОУИС нь 2010 онд Ази номхон далайн бүсийн чанарын сүлжээний гишүүн, 2014 онд Их Британийн Үндэсний магадлан Итгэмжлэх зөвлөлөөр олон улсад анх удаагаа 2017 оны 2 дахь удаагаа магадлан итгэмжлэгдсэн нь хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагын

зорилго зорилт нь олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан гэж үзэхээр байна.

Анхаарах асуудал:

- Оюутны саналыг хөтөлбөрийн төлөвлөлтөд тусгадаг ч системтэй санал асуулга, түүний үр дүнг нэгтгэж албажуулах асуудал учир дутагдалтай байна.

Зөвлөмж:

- Оюутны санал асуулгад хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлагыг үнэлэх асуулга оруулж нэгтгэн дүгнэж үр дүнг хөтөлбөрийн төлөвлөлтөд тусгах ажлыг хийж, албажуулж байх.
- Бусад их, дээд сургуулиудтай хөтөлбөрийн харьцуулалтыг хийхдээ цаашид илүү нарийвчлалтай хийж хөтөлбөрийн төлөвлөлтөд тусгаж байх.
- Ижил мэргэжлээр элсэлт авч байгаа бусад их дээд сургуулиудад элсэхээр бүртгүүлсэн болон элсэн суралцсан хүмүүсийн тоон мэдээлэлд судалгаа хийж дүгнэлт өгвөл энэ мэргэжлийн эрэлтийн талаар нэлээд нарийн дүр зураг гарч болох юм.

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрөөр төгсөгчийн загвар
- Хөтөлбөрийн зорилгыг тодорхойлсон баримт бичиг
- Хөтөлбөрийн зорилгыг тодорхойлох, өөрчлөлтийн талаар олон нийтэд мэдээлсэн баримт материал

Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН

Онцлог зүйл/Туршлага:

- Сургуулийн эрхэм зорилго, Хөтөлбөрийн зорилгыг тодорхойлж уг зорилгыг хангахад чиглэсэн хөтөлбөрийн зорилтуудыг оновчтой байдлаар тодорхойлсон. Хөтөлбөрийн зорилгод хөтөлбөрийн төгсөгчийг загварыг тодорхойлсон.
- Хөтөлбөрийн агуулга, зорилго, зорилтыг мэргэжлийн стандарт, ажлын байрны тодорхойлолт гэх мэт мэргэжилтнүүдэд тавигдах шаардлагад нийцүүлж өөрийн хөтөлбөрийн онцлогийг “Их засаг судлал” “Цогц боловсрол олгох хөтөлбөр”, “Эх оронч үндэсний үзэл, хүмүүжлийн хөтөлбөр” зэргээр тодруулсан.
- Хөтөлбөрөөр суралцагчийн хөтөлбөрийн төгсгөлд эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлагыг тодорхойлсон. Мэдлэг дадал, чадварын үнэлгээг хийх “Лекц, семинарийн хичээл явуулах болон оюутны мэдлэг, чадварыг дүгнэх журам” –ыг баримтдалдаг.
- Хөтөлбөрийн агуулга, зорилго, зорилтыг НББОУС, НББ мэргэжлийн бакалаврын стандарт, НББ-ийн мэргэжилтний мэргэжлийн тодорхойлолт, НББ-ийн мэргэжилтний ажлын байранд тавигдах нийтлэг шаардлагуудад нийцэж байгаа эсэхэд шинжилгээ хийдэг.
- НББ-ийн мэргэжлээр суралцагсдад тавигдаж буй шаардлагыг тодорхойлох, түүний биелэлтийг үнэлэх асуудлын хүрээнд бусад их дээд сургуулиуд мэргэжлийн болон харилцагч байгууллагуудтай эрдэм шинжилгээ, аргазүйн хурал зөвлөгөөн, уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулдаг.
- Хөтөлбөрөөр эзэмших мэдлэг ур чадварын жагсаалт ба хөтөлбөрийн зорилтууд хоорондын уялдаа холбоог матрицаар харуулж уялдаа холбоог үнэлсэн.
- Суралцагч бүрийн хөгжлийг дэмжих чадамжуудыг тодорхойлж хичээлээр болог хичээлийн бус цагаар уг хөтөлбөрийн хүрээнд хийх ажлуудыг тусгасан сургалт, хүмүүжлийн ажил /арга хэмжээ/-ын төлөвлөгөөг хичээлийн жилийн эхэнд гаргаж хэрэгжүүлдэг байна.

- Хөтөлбөрийн хэрэгжилтийг сургалтын төлөвлөгөөнд тусгасан хичээлүүдийн хөтөлбөрийн багаар хэлэлцүүлж, батласан хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөөний дагуу биелэлтийг нь багшийн ажлын дэвтэр, багшийн ажлын тайлан, Их засаг сургуулийн сургалтын нэгдсэн албанаас томилогдсон ажлын гүйцэтгэлийн үнэлгээний баг батлагдсан ажлын удирдамжын дагуу сар бүр хянаж баталгаажуулдаг.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн зорилго, зорилтыг оюутнуудаар хэлэлцүүлэх тэдний саналыг тусгах үйл ажиллагаа тодорхой хэмжээгээр байдаг боловч түүнийг албажуулах, баримтжуулах байдал дутмаг байна.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн зорилго, зорилтыг боловсруулахад оюутны саналын оролцоог нэмэгдүүлэх оюутнуудаас авдаг санал асуулгад уг асуудлыг тодруулах асуулт нэмэх, оюутны саналыг хэрхэн авч нэгтгэн дүгнэж хөтөлбөрийн зорилго зорилтод биелэлээ олсныг баримтжуулж, албажуулах нь уг ажлын ач холбогдлыг нэмэгдүүлэх болно.

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Батлагдсан хөтөлбөр
- Хурлын тэмдэглэл
- Сургалтын нэгдсэн төлөвлөгөө, график /матриц/
- Батлагдсан хичээлийн хөтөлбөр

Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрөөр суралцагчийн хөтөлбөрийн төгсгөлд эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлагыг тодорхойлж, сургалтын төлөвлөгөөнд заасан хичээлүүд ба хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, ур чадвар хоорондын хамаарлыг харуулсан сургалтын төлөвлөгөөний матриц хийдэг.
- НББ мэргэжлийн стандартад заасан мэдлэг, чадвар төлөвшилийг эзэмшүүлэхэд чиглэгдсэн агуулгатай байхаар дараах байдлаар сургалтын төлөвлөгөөг боловсруулж батлуулсан. Үүнд:
 - Ерөнхий суурь хичээл нийт багц цагийн 30 хувиас илүүгүй
 - Мэргэжлийн суурь хичээл нийт багц цагийн 25 хувиас илүүгүй
 - Мэргэшүүлэх хичээл нийт багц цагийн 45 хувиас доошгүй байх.
- НББ-ийн хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөний хүрээнд заадаг хичээлүүдийн хөтөлбөрийг хөтөлбөрийн дэд болон салбар хороогоор хэлэлцүүлж, хичээлийн уялдаа холбоо, сэдвийн давхардал гарахаас урьдчилан сэргийлдэг ситемтэй үйл ажиллагаатай.
- “Их засаг судлал”, “Цогц боловсрол олгох хөтөлбөр”, “Эх оронч үндэсний үзэл, хүмүүжлийн хөтөлбөр”-ийн хүрээнд 7 чиглэлээр 4 жилийн туршид 2 кредит цуглуулах шаардлага тавих байдлаар суралцагчдын бие бялдар, соёл, ёс суртахуун, ёс зүй, харилцаа, хандлагын боловсрол олгодог. Орчин үед чухалд тавигдаж байгаа мэргэжилтний ур чадвар, хандлагыг эзэмшсэн төгсөгч бэлтгэхэд анхаарч сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрт уг асуудлыг тусгадаг нь тус сургуулийн онцлог, давуу тал болно.

- Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээлүүдээр хичээлийн хөтөлбөрийг тэнхмийн эрхлэгчээр хянуулж сургалтын албаны дарга батладаг бөгөөд хичээлийн хөтөлбөрт хичээлийн танилцуулга /хичээлийн тодорхойлолт, зорилго, сургалтын хэлбэр/, хичээлийн хүрэх үр дүн, мэргэжлийн ур чадвар, хувь хүний хандлагыг тодорхойлсон байдаг.
- Оюутанд практик ур чадвар олгох, ажлын байранд бэлтгэх зорилготой НББ-ийн цогц бодлого, курсын ажил, танилцах болон үйлдвэрлэлийн дадлагыг сургалтын төлөвлөгөөнд тусгасан.
- Багш болон оюутан төвтэй практикт суурилсан нийгмийн сүлжээ, онлайн дэмжлэгийг агуулсан, үзүүлэн тараах материалыг ашигласан сургалтын аргазүйн зураглалыг хийж уг зураглалд тусгагдсан арга аргачлалаар оюутанд мэдлэг, ур чадвар, хандлагыг эзэмшүүлэх зорилт тавьдаг.
- Багш бүр хичээлийн хөтөлбөрийн сэдэв бүрээр лекц, семинар, лабораторийн болон бие даалтын ажлуудыг төлөвлөдөг бөгөөд багш бүр хичээл бүрээр хичээлийн багц материалыг сургуулиас тогтоосон стандартын дагуу бэлтгэж файл /хавтас/ бэлтгэж ажилладаг.
Тухайлбал:
 - Лекцийн хичээлийн конспект, РРТ танилцуулга, унших материал
 - Семинарын хичээлийн удирдамж, ашиглах болон тараах материал
 - Бие даалтын ажлын удирдамж, даалгавар
 - Шалгалтын асуултын жагсаалт

Анхаарах асуудал:

- Томоохон ажил олгогчийн төлөөллүүдийн Нягтлан бодогчийн ажлын байрны тодорхойлолтыг судласан судалгаа, анализ, үр дүнг хичээлийн хөтөлбөрийн төлөвлөлтөд хэрхэн тусгасныг албажуулуулах.

Зөвлөмж:

- Хичээлийн хөтөлбөрт хичээлийн сэдэв тус бүрийг тухайн хичээлийн сургалтын үр дүнтэй уялдуулж тодорхойлсон төлөвлөгөөний биелэлтийн байдалд хяналт үнэлгээ хийдэг байх.

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

- Хичээлийн индекс, хичээлийн суралцахуйн үр дүнгийн матриц
- Удирдлагын мэдээллийн систем дэх сонголтууд
- Сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд хийсэн шинжилгээ
- Дадлагын талаар хамтран ажиллах гэрээ, санамж бичиг, удирдамж, журам, ажлын тайлан, анализ
- Хичээл хоорондын залгамж холбоог харуулсан график /хөтөлбөрийн мод/
- Суралцагчийн цагийн ачаалал тооцсон судалгаа

Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН

Онцлог зүйл/Туршлага

- НББ-ийн хөтөлбөрийг 2006, 2008, 2012, 2018 онуудад шинэчилсэн. 2018 онд дотоодын болон гадаадын зарим их дээд сургуулиудын ижил, төстэй мэргэжилтэн бэлтгэдэг хөтөлбөөд харьцуулсан судалгаа хийж бенчмарк хийх замаар кредит цагийн хуваарилалт болон агуулгын хувьд өөрчлөлт оруулсан зэргээр сургалтын хөтөлбөрийн агуулгыг тасралтгүй сайжруулах арга хэмжээг авч иржээ.
- Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай байдлыг хангасан эсэхийг сургалтын төлөвлөгөөнд тусгасан хичээлүүдийн залгамж, уялдаа холбоог тодорхойлсон зураглал хийж шинжилгээ хийсэн.
- НББ-ийн хөтөлбөрийн агуулгад багтсан хичээлүүдийн нэгдсэн стандартыг шинэчилж тогтоож сургалтын чанарын удирдлагыг нэвтрүүлэх боломжийг нэмэгдүүлсэн. Оюутан XCLOUD программаар хичээл сонголтыг хийдэг.
- Сургалтын төлөвлөгөөнд ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэшүүлэх хичээлийн зохистой харьцааг холбогдох байгууллага, дүрэм журмаар тодорхойлсон шалгуурт нийцүүлж баримталсан бөгөөд оюутанд сонгон судлах боломжтой хичээлүүдийг тусгаж өгсөн тухай сургалтын төлөвлөгөөнд хийсэн өөрчлөлтүүдийн тухай шинжилгээ хийж тайланг бэлтгэдэг.
- Суралцагч хос мэргэжил эзэмшиж төгсөх боломжийг зөвшөөрсөн тушаал шийдвэр гарсан бөгөөд оюутан 3-р курсээс өөрийн мэргэжлийн зэрэгцээ бусад мэргэжлийн хичээлийг нэмж судлан суралцах боломжтой болж байгаа. Ирэх хичээлийн жилд 3-р курсэд суралцах оюутнууд санал хүсэлт гаргаснаар энэ үйл ажиллагаа хэрэгжих боломжтой болно.
- Сар бүр ажлын гүйцэтгэлийн үнэлгээний баг /АГҮБ/ ажиллаж багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлдэг тогтолцоотой.
- Комьпютрийн хэрэглээ хичээлүүд дээр шинжилгээ судалгаанд түлхүү хэрэглэх SPSS, Data analysis, E-views програмуудыг ашигладаг.
- Төгсөгчид, дадлага хийж буй оюутнуудыг ажлын байраар хангадаг ААН, байгууллагуудаас ирүүлсэн саналд үндэслэж Интерактив ХХК-ийн Даймонд программын компьютерийн лаборатори байгуулж сургалтанд ашиглаж байна.
- Оюутны цагийн ачааллыг 7 хоногт дунджаар 18 цагийн танхимын хичээлийн ачаалалтай байхын зэрэгцээ бие даалтын нэг өдрийг хичээлийн хуваариар гаргаж өгч, оюутан өөрийгөө хөгжүүлэх, бие даалт, гэрийн даалгавраа хийх, багшаас зөвлөгөө авах зэрэг боломжийг бүрдүүлж ажилладаг.

Анхаарах асуудал:

- Хичээлийн хөтөлбөрийн дагуу хичээлийн үр дүнд оюутанд олгох мэдлэг, чадвар, хандлагыг тодорхойлж гаргасан боловч хичээл заасан багш, хичээлийн баг хүрсэн үр дүнг хэмжих, анализ дүгнэлт хийж хичээлийн хөтөлбөр, агуулга, арга аргачлалд өөрчлөлт сайжруулалтыг хийдэг тогтсон системийн үйл ажиллагаа дутмаг.

Зөвлөмж:

- Хичээлийн хөтөлбөрийн дагуу хичээл бүрээр хичээл заасан багш, хичээлийн баг хичээлийн үр дүнг хэрхэн хангаж байгааг үнэлэх үнэлгээний хөтөлбөр боловсруулж, уг хөтөлбөрийн дагуу шууд болон шууд бус аргаар үнэлгээ хийж уг үнэлгээний үр дүнг хичээлийн хөтөлбөрийн шинэчлэлт, сайжруулалтад хэрхэн тусгасныг албажуулж баримтжуулдаг тогтсон системийг бий болгох.
- Оюутан багш болон хичээлээ сонгох боломжийг бүх талаар нээх

- 3-р курсээс өөрийн мэргэжлийн зэрэгцээ бусад мэргэжлийн хичээлийг нэмж судлахад тэдний ачаалалыг жигд хуваарилах тогтолцоог бүрдүүлэх

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын аргазүйг хэрэгжүүлэх загвар, заавар, зөвлөмж
- Сургалтын аргазүйд хийсэн анализ судалгааны баримт материал

Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН

Онцлог зүйл/Туршлага:

- Хичээлийн хөтөлбөрийн шинэчлэл сайжруулалтыг сургалтын нэгдсэн алба, Хөтөлбөрийн хороо хянаж ажилладаг тогтсон системтэй.
- Сургалтын төлөвлөгөө, түүнд тусгасан хичээл бүрийн агуулга, стандарт, хичээлийн хуваарийг баримтлан сургах үйл ажиллагааг магистр түүнээс дээш зэрэгтэй багш удирдан явуулдаг.
- Хичээл бүрээр багшийн бэлтгэж хичээлд ашиглаж байгаа хичээлийн багц материалын бүрдүүлэлт, хичээлийн хөтөлбөрийн хэрэгжилт зэргийг хөтөлбөрийн баг, тэнхим, сургалтын нэгдсэн албанаас томилогдсон Ажлын гүйцэтгэлийн үнэлгээний баг тогтоосон хугацаанд хяналт тавьж ажилладаг.
- Сургалтын үйл ажиллагааг оюутан төвтэй тэдний оролцоог дэмжсэн, үйлээр дамжуулан сургах, төсөлд суурилсан идэвхтэй арга хэлбэрийг хослуулсан байхыг сургалтын стандарт, арга аргачлалуудыг мөрдлөг болгож байгаа эсэхийг хичээлийн хөтөлбөр, сургалтын багц материалыг хянах байдлаар хэрэгжүүлдэг.
- Оюутанд мэдлэг чадвар олгохдоо мэдээлэл харилцааны дэвшилтэт технологийг дараах хэлбэрээр ашигладаг. Үүнд:
 - Мэргэжлийн хичээлийн ном, сурах бичиг бүхий вертуал номын сан
 - Сургуулийн цахим хуудас, FB хуудсаар оюутнуудтай харилцах хичээлийн материалыг түгээх, зөвлөгөө өгөх, бие даалт гэрийн даалгаврын ажлыг чиглүүлэх
 - XCloud програмаар лекцийн болон унших нэмэлт материалыг түгээх
- Багшийн сургах арга зүйг хөгжүүлэх тал дээр анхаарч ажилладаг бөгөөд орчин үеийн болон шинэ арга технологийг нэвтрүүлж буй туршлагаасаа хуваалцаж нээлттэй хичээлийг зохион байгуулдаг. Шилдэг арга зүйтэй багш нарыг сургуулийн зүгээс сайшааж ажлын үр дүнг үнэлэхэд харгалзан үздэг. 2018-2019 оны хичээлийн жилийн эхний хагас жилд 5 ахлах зэрэгтэй багш, 6 залуу багш үзүүлэх болон нээлттэй хичээлийг зохион байгуулсан байна.
- Сургалтын арга зүйн үр дүн ахиц дэвшлийн талаар судалгаа хийж, улирал бүрийн амжилт, чанарын үзүүлэлтийг өмнөх оны үзүүлэлттэй харьцуулан дүгнэлт хийдэг.

Анхаарах асуудал:

- Цахим ном, цахим сэтгүүл, эрдэм шинжилгээний бүтээлийг ашиглах талаар төлөвлөсөн ажлууд байгаа бөгөөд эдгээрийг хэрэгжүүлэхэд анхаарах.

Зөвлөмж:

- Багш, оюутнууд цахим эх үүсвэрээс шаардлагатай сурах бичиг, судалгааны ажил, мэдээллийг олж авах ашиглах боломжийг нэмэгдүүлэх

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтад ашиглаж буй үнэлгээний аргазүйн судалгаа. /Блум таксономи, Рубрик арга г.м/
- Хичээл нэг бүрийн үнэлгээнд хийсэн дүн шинжилгээ, анализ /Шалгалтын хэлбэр, асуулт даалгавар, сорилын санд хийсэн шинжилгээ/
- Явцын болон төгсөлтийн шалгалтын журам
- Суралцагчийн сурлагын амжилт, ахицын талаарх статистик мэдээлэл, боловсруулалт, дүгнэлт /голч дүн, хичээлд унасан оюутны тоо, сурлагын амжилт, чанар гэх мэт/

Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН

Онцлог зүйл/Туршлага:

- Суралцагчид олгож буй мэдлэг, ур чадварыг үнэлэхдээ боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас батласан “Их дээд сургууль, коллежийн суралцагчдын мэдлэг, чадвар, дадлыг үнэлж дүгнэх журам”-ыг удирдлага болгон сургуулийн лекц, семинарын хичээл явуулах болон оюутны мэдлэг, чадварыг дүгнэх журам баталж түүнийгээ баримталдаг.
- Сургалтын үйл ажиллагаа, удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах, тухайн үед үүссэн нөхцөл байдлыг шийдвэрлэх талаар гарсан хүсэлтийг хүлээн авч ИЗИС-ийн шалгалтын үнэлгээтэй холбоотой гомдлыг барагдуулах журмыг баримтлан асуудлыг шийдвэрлэж шийдвэр гаргадаг комисс ажилладаг.
- Оюутны үнэлгээнд хөндлөнгийн үнэлгээний арга аргачлалыг тодорхой хэмжээнд нэвтрүүлсэн. Оюутан сурлагын голч дүн ахиулах, оюутан шилжин ирж суралцах зэрэгт хөндлөнгийн үнэлгээний баг сургалтын албанаас томилж шалгадаг журам, системтэй.
- Сургалтын үйл ажиллагаанд хичээлийн семестрийн дундуур хичээлийн хөтөлбөр, хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөөнд тусгасан сэдвийн хүрээнд тестийн сангаас тест бүрдүүлж шалгалт авч мониторинг хийж багшийн ажилд үнэлгээ өгдөг.
- Хичээлийн явцад амжилттай суралцсан суралцагчийг улирлын болон анги дэвших шалгалтаас чөлөөлөх тогтсон журамтай байгаа нь оюутны ачаалал, стрессийг бууруулах явцын дунд чармайлттай суралцах, аливаа даалгавар шалгалтыг тухайн цагт нь амжилттай гүйцэтгэхийн тулд хүчин чармайлт гаргахад сэдэлжүүлэлт болохоор байна.
- Сургуулийн нэгдсэн алба, цогцолбор, салбар, харьяа сургуулийн захиралын тодорхойлолтоор сургуулийн дотоод журамд заасан үйл ажиллагаанд идэвхитэй оролцсон оюутанд тодорхой хязгээрт багтаан урамшууллын оноо өгч суурь оноон дээр нэмж дүгнэж болохор журамласан нь оюутны нийгмийн хариуцлага, хандлагыг сайжруулахад түлхэц болох туршлага байна.
- Сурлагын амжилт, чанарын үзүүлэлтийг сүүлийн 4 хичээлийн жилээр харьцуулсан судалгаа хийсэн.
- Оюутныг үнэлж дүгнэх, өмнө нь судласан 2 хүртэл хичээлээр тухайн улиралд сурлагын амжилтыг ахиулах шалгалт өгч голч дүнгээ ахиулах оюутанд олгодог тогтсон журмын дагуу хэрэгжүүлдэг.
- Хичээлийн хөтөлбөрт улирлын яоц дундун болон улирлын шалгалтын асуултууд, тулгуур болгон ашиглах ном сурах бичиг, унших материалын жагсаалтыг тусгаж өгдөг.

- Багш нарыг 2 жил тутамд аттестатчилалд хамруулан суралцагч нарын мэдлэг, чадварыг дээшлүүлэхэд хэрэгжүүлж байгаа сайн туршлагыг хуваалцаж бусад багш нарын ажилд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулдаг.
- Хичээл бүрээр багш оюутны тухайн хичээлээр олж авсан мэдлэг, чадвар, хандлагыг хэрхэн үнэлэх тухай мэдээллийг хичээлийн хөтөлбөрт тусгах байдлаар суралцагсад хичээлийн улирлын эхэнд мэдэгддэг.
- Хичээл бүрээр улирал дундын шалгалтыг авах хэлбэр, дүгнэх аргачлалд сургуулийн хяналт, үнэлгээний багийн ажлын тайлан, багшийн санал зэргийг харгалзан өөрчлөлт оруулж шинэчилдэг.

Анхаарах асуудал:

- Суралцагчийн үнэлгээний нийт оноонд оюутны гэрийн даалгавар, бие даалтын онооны эзлэх хувийн жин бага байна. Энэ нь хичээлийн нийт кредит цагийн агуулгад бие даалтын цагийн эзлэх хувь бага байгааг илтгэж байна гэж үзэж болохоор байгааг анхаарах.

Зөвлөмж:

- Оюутны шалгалтыг интернэт технологийн орчин үеийн дэвшилтэт арга аргачлалыг ашиглаж хөндлөнгийн үнэлгээ хийж авах \Зарим хичээлүүдийн хувьд\.
- Оюутанд бие даалтын даалгаврын агуулгыг тухайн хичээлийн нийт агуулгад /кредитэд/ бие даалтын цагийн эзлэх хувийн жинг нэмэгдүүлэх.

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо:

- Хичээлийн байр, сургалтын анги танхим, лабортори, урлан, бие даан болон багаар ажиллах орчны хүрэлцээ, хангамж, ашиглалтын сэтгэл ханамжийн судалгааны үр дүн, хийсэн ажлын тайлан
- Сургалтын тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн хэрэгсэл, цахим орчны ашиглалт, хүртээмж, сэтгэл ханамжийн судалгаа

Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН

Онцлог зүйл/Туршлага:

- НББ хөтөлбөр нь Их Засаг Санхүү Эдийн Засгийн сургуульд харьяагдах бөгөөд сургууль өөрийн гэсэн тусдаа байртай. 2019 оны 9 сараас 8 давхар шинээр баригдаж буй сургуулийн байранд үйл ажиллагаа явуулах боломжтой байна.
- Сургалтын анги танхим LCD прожектор, ухаалаг самбар, компьютер, ханын самбар, үзүүлэн болон шаардлагатай тоног хэрэгслээр бүрэн тоноглогдсон.
- Хөтөлбөрийн оюутнууд 3 компьютерийн лабораторийг сургалтанд ашигладаг. Эдгээр лабораториудад Diamond, SPSS, E-views зэрэг програмуудыг суулгажээ. Хичээлийн бус цагаар оюутнууд эдгээр компьютерийг ашиглах нь чөлөөтэй байна.

- Хичээлийн байр, сургалтын анги танхим, лабортори, урлан, бие даан болон багаар ажиллах орчны хүрэлцээ, хангамж, ашиглалтын сэтгэл ханамжийн судалгааны үр дүн, хийсэн ажлын тайлан
- Ажлын гүйцэтгэлийн үнэлгээний багаас сар болгон оюутнуудаас сэтгэл ханамжийн судалгаа авна \оюутнуудаас номын хүртээмж, сургалтын үйл ажиллагаа, багшийн заах арга зүй, сургалтын орчин, дотуур байрны талаар авна.
- Хичээлийн байр, дотуур байранд wifi орчин бүрдсэн. Багш, оюутнуудад юнителийн дугаар үнэгүй тараасан.
- Сургалтын гарын авлага, тараах материалыг оюутны хүртээл болгохдоо өөрийн хэвлэх цехээр хэвлэж тараадаг. Багш нарын хэрэгцээний компьютер, програм хангамж хангалттай.
- Багш нар мэдээллийн эх үүсвэрийг Блог ажиллуулдаг байснаа Slide Share, фейсбүүк, харилцах чат ашиглаж удирдлага-багшийн мэдээлэл солилцдог. Багш-оюутантайгаа мэдээлэл солилцохдоо xCloud програм ашигладаг.
- Нэг багшид 200.0-250.0 мянган төгрөгийг бичиг хэрэгсэл, принтерийн хор, хоол унааны нэмэгдэлд нийтэд нь өгдөг. Үүний 90.0 мянга нь хоол, унааны зардал байна.

Анхаарах асуудал:

- Сургалтын орчны талаарх сэтгэл ханамжийн судалгааны дүнг тайланд тусгах

Зөвлөмж:

- Дотуур байрны барилга хуучирсан тул засвар, үйлчилгээг хийж орчныг сайжруулах.

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын хэрэглэгдэхүүн, нөөцийн жагсаалт, хүртээмж, ашиглалт, сэтгэл ханамжийн судалгаа
- Сургалтын ажлыг зохион байгуулах заавар, удирдамж, зөвлөмж
- E-контент түвшинд боловсруулсан сургалтын материал

Шалгуурыг хангасан байдал: ХЭСЭГЧЛЭН ХАНГАСАН

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтын xCloud програм ашигладаг. Уг програмд багшийн хичээлийн материалыг оруулж оюутнууд ашиглах боломжийг бүрдүүлжээ. Хөтөлбөрт хичээл заадаг нийт багш 30 багшаас 16 багш буюу 53.3 хувь нь сургалтанд ашигладаг хичээлийн материалыг иж бүрэн програмд оруулсан байна.
- Хичээл болгоноор явцын болон улирлын шалгалт авдаг. Эдгээр шалгалтууд нь багшийн үзэмжээр шийдвэрлэгдэхгүй, шалгалт авах нэгдсэн журмын хүрээнд асуулт, тест боловсрогдож шалгалтыг авдаг. Тухайлбал, улирлын шалгалтыг нийт 40 –оос доошгүй асуулттай тестээр авна гэх мэт журмаар зохицуулсан байна.
- Оюутны гарын авлага, Оюутны өврийн дэвтэр хэвлүүлж элссэн оюутан бүрт үнэгүй тараадаг.
- Сургалтын үйл ажиллагаанд буюу явцын болон улирлын шалгалтыг дүрэм, журмын хүрээнд авч буй эсэх, хичээлийн технологийн мөрдөлтөнд Сургалтын алба хяналт тавьж ажилладаг. Мөн Их Засаг Их Сургуулийн Ажлын гүйцэтгэлийн алба \Дотоод аудит\-наас судалгаа авч хяналт тавьдаг.
- Сургалтын ажлыг зохион байгуулах тогтсон дүрэм, журмыг хөтөлбөрийн багш нараар хэлэлцүүлж баталгаажуулсан байна.

Анхаарах асуудал:

- Хичээл тус бүрийн улирлын шалгалтын тестийн сан нь 3 түвшинтэй боловч нийтдээ 90 асуултаас бүрдэж байгаа нь цөөн байна.
- Е-контент түвшинд боловсруулсан сургалтын материал хөтөлбөрийн нийт багш нарын 53.3 хувь эзэлж байгаа тул цаашид бүх багш нар Е-контент түвшинд сургалтын материалаа бэлтгэхэд анхаарах.

Зөвлөмж:

- Оюутнууд тестээр улирлын шалгалт өгөх тохиолдолд тестийн санг баяжуулах, мөн онлайнаар компьютерийн лабораторид шалгалт авах боломжийг бүрдүүлэх.
- Оюутны бие даах ажлын хүрээнд ашиглах сургалтын материалыг цахим орчинд бүрдүүлэх.

3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

-Үндсэн сурах бичиг, гарын авлага, эрдэм шинжилгээний сэтгүүлийн жагсаалт, сэтгэл ханамжийн судалгаа.

-Мэргэжлийн ном, сурах бичгийн баяжилт, шинэчлэлтийн судалгаа

-Цахим мэдээллийн сан, нээлттэй эх үүсвэрийн ашиглалтын судалгаа.

Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН

Онцлог зүйл/Туршлага:

- Сүүлийн 3 жилийн дунджаар нэг жилд 3.7 сая төгрөгийн 300-400 ширхэг ном худалдан авсан байна.
- Номын хүртээмж, номын сангийн үйл ажиллагааны талаар болон бусад санал гомдол тодруулах зорилгоор Оюутны сэтгэл ханамжийн судалгааг Номын сангийн захиргаа, Их Засаг СЭЗ-ийн хөтөлбөрийн баг болон Ажлын гүйцэтгэлийн албанаас 3 зэрэг судалгаа авдаг. Уг судалгааны үр дүнгээр товхимол хэвлэн гаргасан ба гарсан санал, хүсэлтийн дагуу тухайн хичээлийн жилд шинэ ном худалдан авдаг.
- “Номын сангийн оюутны зөвлөл” гэсэн нэртэй зөвлөл ажилладаг. Уг зөвлөлийн гишүүд нь нийт 8 оюутнаас бүрдэх ба тэд номыг наах, сэргээн засах ажил хийж оюутны төлбөрийн 10.0 хувь хөнгөлөлт эдэлдэг.
- Мэргэжлийн суурь болон мэргэшүүлэх хичээлийн үндсэн сурах бичиг, гарын авлага, эрдэм шинжилгээний сэтгүүлийг номын санд бүрэн авсан. Багш нарын санаачлагаар мэргэжлийн сэтгүүлүүдийн жагсаалтыг жил бүр шинэчилж захиалдаг.

Анхаарах асуудал:

- Оюутнуудын цахим мэдээллийн сан нь xCloud програмаар хязгаарлагдаж байна.
- Мэргэжлийн ном, сурах бичгийг номын санд бүрэн авсан боловч нэг номны худалдан авсан дээд хэмжээ нь 10 байгаа тул цаашид хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд худалдан авах тоо хэмжээг нэмэгдүүлэх хэрэгтэй юм.

Зөвлөмж:

- Цаашид багш нар IF-тай сэтгүүлийг онлайнаар ашиглах эрхийг худалдан авах.
- Оюутнуудын цахим номын сангийн хэрэглээг өсгөх.

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн хороо, профессорын баг, тэнхимийн хурлын шийдвэр, тэмдэглэл
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой эрхзүйн баримт бичиг, эрхзүйн баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ
- Хөтөлбөрт ирсэн санал гомдол, шийдвэрлэлтийн тайлан
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн урт, дунд, богино хугацааны тайлан, төлөвлөгөө.
- Тайлан төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ
- Сургалтын удирдлага, мэдээллийн системийн ашиглалт, хяналт, ил тод байдалд хийсэн дүн шинжилгээ.

Шалгуурыг хангасан байдал: ХЭСЭГЧЛЭН ХАНГАСАН

Онцлог зүйл/Туршлага:

- Сургуулийн стратеги төлөвлөгөө, дунд хугацааны стратеги төлөвлөгөөг 2007, 2009 онуудад батласан бөгөөд уг төлөвлөгөөнд НББ-ийн бакалаврын сургалтыг тогтвортой, боловсролын шинэчлэлд нийцсэн сургалт явуулах, багш нарын багийг бүрдүүлж чадваржуулах бодлогыг тодорхойлсон.
- Сургуулийн удирдлагын зүгээс нэгдсэн мэдээллийг дамжуулахдаа багшийн болон оюутны программыг хөгжүүлж мэдээллийн сангийн бүрдүүлэлт боловсруулалтыг хийдэг.
 - /http:teacher-web.xcloud.mn/login/ ,
 - /http:student-web.xcloud.mn/login/ ,
 - /http:monitor-web.xcloud.mn/login/ ,
- Нийт багш, ажилтнуудын ажлын цагийг хурууны хээгээр бүртгэж, цахимаар нэгтгэж боловсруулалт хийж бүртгэл, тайлагнал, хяналтыг хийдэг.
- Сургуулийн байр, оюутны байр, саажилттай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сувилалын цэцэрлэг, сувилал зэрэг байгууллагуудыг аюулгүй ажиллагааны хяналтын систем, камержуулалтаар бүрэн хангасан.
- Сургуулийн ректорын ажлын албанаас сургуулийн стратеги төлөвлөгөө, чанарын зорилт, тухайн жилийн БСШУЯ-аас гаргасан ерөнхий чиглэлтэй уялдуулан сургуулийн тухайн хичээлийн жилд хийх үндсэн чиглэлийг гаргаж түүнд үндэслэн бүрэлдэхүүн сургууль, алба нэгж, хөтөлбөрийн баг үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж мөрдөж ажилладаг.
- Хөтөлбөрийн шинэчлэл, өөрчлөлтийн хэрэгжилтийн явц байдалд их сургуулийн эрдэм шинжилгээ эрхэлсэн захирал, сургалт эрхэлсэн захирал, ажлын гүйцэтгэлийн баг үнэлгээ хийж хяналт тавьж аргазүйгээр хангаж ажилладаг.
- Улирлын болон жилийн эцэст сургалтын төлөвлөгөө, сургалтын хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэнд хөтөлбөрийн баг үнэлгээ, дүгнэлт хийж тайлан бэлтгэдэг.
- Сургуулийн удирдлагын үүрэг нь нэгдсэн удирдлага, зохицуулалт, аргазүйн удирдлагаар хөтөлбөрийг хангах, санхүү эдийн засгийн нөөцийг төлөвлөх, бүрдүүлэх, зарцуулалтыг төлөвлөх хяналт тавих үндсэн үүрэгтэй болохыг сургуулийн холбогдох дүрэм журам, үйл ажиллагааны төлөвлөгөө, багш ажилтнууд, оюутнууд, бусад оролцогч талуудтай байгуулсан гэрээгээр баталгаажуулдаг.
- Багш ажилтны ёс зүйн хороо, оюутны үйлчилгээний төв, хүний нөөцийн мэдээллийн системээр санал гомдлыг хүлээн авч шийдвэрлэдэг.
- СЭЗС-ийн төгсөгдийг ажлын байранд бэлтгэх үйл ажиллагааны төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэх төсөвийг баталж, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангаж биелэлтэд тогтмол хяналт тавьж ажилладаг. Тухайлбал:

- Сонгинохайрхан дүүргийн хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэстэй хамтран ажиллах гэрээний дагуу төгсөгчидтэй уулзалт зохион байгуулах
- Сонгинохайрхан дүүргийн хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсийн мэргэжилтнүүдээр /3 хүн/ мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээ
- Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газартай хамтран ажиллах гэрээний дагуу төгсөгчидтэй уулзалт зохион байгуулах
- Сэтгэл судлал, эерэг сэтгэлгээний төлөвшил зэрэг асуудлаар мэргэшсэн салбарын тэргүүлэгч эрдэмтэн, мэргэжилтнүүдээр лекц уншуулах гэх мэт
- Нийгмийн хариуцлагатай байх ажлын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй /саажилттай/ хүүхдийн асрамжийн цэцэрлэг, багш ажилтнууд, суралцагсад болон нийтэд үйлчлэх “Ариун лотус” сувилал зэргийг байгуулж ажиллуулан манлайлдаг.
- Сургуулийн дотоод хяналтын чиг үүрэг бүхий ИЗОУИС-ын ажлын гүйцэтгэлийн үнэлгээний алба /АГҮБ/ сургуулиудаас ирүүлсэн мэдээ, тайланд үндэслэн удирдамж боловсруулж хөтөлбөрийн хэрэгжилт болон үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавих ажлыг сар бүр хийж гүйцэтгэн, удирдамжид заасан үзүүлэлтээр дүгнэсэн онооны нийлбэрээр бүрэлдэхүүн сургуулиудыг байр эзлүүлж тэргүүлсэн сургууль, хөтөлбөрийг урамшуулах, илэрсэн доголдол дутагдлыг засах талаар зөвлөмж чиглэл өгөх, зарим ажлыг биечлэн хийж үзүүлэх зэргээр туслан дэмжих, удирдлагаар хангах ажлыг хэрэгжүүлдэг нь хөтөлбөрийн чанарыг тасралтгүй сайжруулах арга хэмжээ болдог.
- Бүрэлдэхүүн сургуулиуд дээрх оюутны үйлчилгээний төвүүдийг нэгдсэн удирдлагаар хангах, оюутнуудаас сэтгэл ханамжийн судалгаа, хичээлийн байр, оюутны байр, номын сангуудад саналын хайрцаг ажиллуулж санал хүсэлтийг хүлээн авч үр дүнд үндэслэн асуудлыг шийдвэрлэх зорилго бүхий оюутны үйлчилгээний төв, оюутны үйлчилгээний хороог байгуулж нэгдсэн удирдлага, аргагүйгээр хангаж ажилладаг.
- Багш нарын хөдөлмөрийн гэрээнд хичээлийн хөтөлбөр, багц материалыг шинээр боловсруулах, нэмэлт өөрчлөлтийг хийх зэрэг ажил болон ажлын үр дүнгийн байдлыг хөдөлмөрийн гэрээг дүгнэх нэг үзүүлэлт болгож хөтөлбөрийг боловсронгуй болгох хөшүүрэг болгодог.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч гол оролцогч тал болох багш ажилтны нөөцийг бүрдүүлэх, хөгжүүлэх, ажлын гүйцэтгэлийг үнэлэх, урамшуулах тодорхой бодлогыг баримталж холбогдох хөтөлбөр, дүрэм журмыг боловсруулж эрхзүйн орчныг бүрдүүлсэн.
- Сургуулийн хэмжээгээр оролцогч болон сонирхогч талуудын санал гомдлыг
 - Санал хүсэлтийн хайрцаг
 - Өргөдлөл, хүсэлтээр
 - Биеэр ирж уулзах
 - Сэтгэл ханамжийн судалгаагаар
 - Интэтээр /e-mail, FB хуудас/ зэрэг хэлбэрүүдээр хүлээн авч холбогдох албадууд шийдвэрлэдэг тогтсон системтэй.
- Дүүрэг, хорооны цагдаагийн байгууллагатай хамтарч ажиллан сургуулийн орчин, оюутнуудыг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, үүссэн асуудлыг ёсзүйн дүрэм, сургуулийн дүрмийн дагуу шийдвэрлэдэг.

Анхаарах асуудал:

- НББ-ын мэргэшсэн нягтлан бодогч зэрэгтэй багш 2 байгаа нь нийт НББ-ын багшийн тоотой харьцуулахад бага үзүүлэлт юм. Иймд НББ-ийн мэргэжлийн багш нарыг дотоодын болон ОУ-ын мэргэжлийн зэрэгтэй болгох, тоог нэмэгдүүлэх

Зөвлөмж:

- ТМЗ нийгэмлэг болон ММНБИ институт гэх мэт мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах, тэдний үйл ажиллагаанд багш нараа оролцуулах замаар хөтөлбөр, сургалтын аргагүйг сайжруулахад дэмжлэг үзүүлж болох юм.
- Мэргэшсэн нягтлан бодогч, татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогч, мэргэшсэн үнэлгээчин, аудитор гэх мэт дотоодын болон мэргэжлийн олон улсын зэрэгтэй багшийн тоог нэмэгдүүлэхэд удирдлагын зүгээс тодорхой дэмжлэг үзүүлэх замаар хөтөлбөрийн чанарыг тасралтгүй сайжруулахад анхаарч болох юм.

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Хэрэгжүүлж буй хамтарсан төсөл, хөтөлбөрүүдийн гэрээ, хэлцэл, ажлын тайлан
- Багш, суралцагч солилцоо, тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдагсдын тоон судалгаа, дүрэм журам
- Нийгэмд үзүүлсэн үйлчилгээний хэлбэр, хамрагдагсдын тоо, үр дүн, ажлын тайлан, дүгнэлт /багш, суралцагчдын зүгээс/
- Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааны баримт материал
- Төгсөгчдийг давтан сургалтад хамруулсан талаарх тоон мэдээлэл

Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН

Онцлог зүйл/Туршлага:

- 2005 оноос гадаад харилцааны бие даасан алба байгуулсан. ИЗОУИС нь 2018 оны 11-р сарын байдлаар ОХУ, БНХАУ, Япон, БНСУ, АНУ, Франц, Австрали, Малайз, Их Британи, Сингапур, Кипр зөрөг 10 гаруй улс орны 50 гаруй их, дээд сургууль, боловсрол шинжлэх ухааны байгууллагатай хамтран ажиллаж, эрдэмтэн судлаач, багш, оюутан солтлох, соёл мэдээллийн төв байгуулах, хамтарсан сургалт зохион байгуулах, сургалтын материал, ном сурах бичиг солилуулах, мэргэжил олгох хамтарсан сургалтын төв наах, багш нарын мэргэжлийг дээшлүүлэх сургалт зохион байгуулах, судалгааны төсөл дээр хамтарч ажиллах зэрэг хэлбэрээр гадаад хамтын ажиллагааг хөгжүүлсэн байна.
- Эдийн засаг, НББ-ийн хичээлийн хөтөлбөрийг боловсруулахдаа ОХУ-ын Буриадын ИС, БНХАУ-ын Хэбэйн СЭЗС, Япон улсын Осакагийн Эдийн засаг хуулийн сургууль, Сингапурын Менежемент хөгжлийн институт зэрэг сургуулиудын туршлагыг судлаж танилцсан байна. 2011 онд Сингапурын удирдлагын менежементийн институтын сургалтын хөтөлбөрийг нэвтрүүлж ашиглах гэрээ байгуулсан.
- Сургалтын хөтөлбөрөө ОУ-ын байгууллагаар магадлуулах зорилго тавьж 2011 онд ACBSP байгууллагад гишүүнээр элсэж, тус байгууллагын магадлан итгэмжлэлийн шалгуур, шаардлагыг судлах, хөтөлбөрийн үйл ажиллагаанд хэрэгжүүлэх үүднээс ээлжит хурлуудад багш нарыг оролцуулсан. ОУ-ын болон үндэсний стандартыг үйл ажиллагаандаа мөрдлөг бологж ажиллах талаар анхаардаг.
- Хөтөлбөрийн чанараа сайжруулах, төгсөгчдийн ажил эрхлэлтийг дэмжих зорилгоор МУИС, Мандах их сургууль, ШУТИС, БХИС, ШУА, Монголын их дээд сургуулиудын консерциум, Хувийн ИДС-иудын холбоо, ММНБИ, ММенежементийн холбоо, БЭЗС Консерциум, Монголын аудитын холбоо, ТМЗ нийгэмлэг, ММУХолбоо, Дүүргүүдийн татварын хэлтэс, ҮСХороо зэрэг байгууллагуудтай хөтөлбөрийг шиэчлэх хүрээнд мэдээлэл солилцох, туршлага судлах мэргэжлийн сургалт, семинар зохион байгуулах, уралдаан тэмцээн, олимпиад, ЭШХ-д багш оюутнуудаа оролцуулах зэргээр хамтран ажилладаг.

- Байгууллагын ололт амжилт, удирдлага, чанар, шинэ санаачилга, шинэ технологи, нийгмийн нэр хүнд зэргээр шалгуур тавьдаг VID байгууллагын 20 дахь удаагийн алтан категорын ОУ-ын чанарын баталгаажуулалтын “Хаан титэм” шагналыг хүртсэн.
- ИЗОИС-ийн Малайз улсын Лимкоквины их сургуультай байгуулсан гэрээний дагуу эрдэм шинжилгээ судалгааны аргазүйд суралцах, мэргэжил дээшлүүлэх сургалтанд СЭЗ-ийн багш нарыг /нэр бүхий 3 багш/-ыг хамруулсан.
- Дотоодын их дээд сургууль, байгууллагын хүрээнд МУИС-ын БС, ШУТИС, Батлан хамгаалахын их сургууль, Мандах бүртгэл их сургууль, ШУ-ны академи, Монголын их дээд сургуулиудын консерциум, Хувийн их дээд сургуулиудын холбоодууд зэрэг байгууллагуудтай хөтөлбөрийн агуулга, чанарыг сайжруулах, хөтөлбөрийг шинэчлэх, хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ажлын хүрээнд мэдээлэл солилцох, туршлага судлах зэргээр хамтарч ажилладаг.
- НББ-ийн хөтөлбөрийн оюутнуудыг тэтгэлэгт хөтөлбөрт хамруулдаг.

Анхаарах асуудал:

- ИЗОУИС-ийн түвшинд Эрхүүгийн их сургууль, Өвөрмонголын Багшийн их сургууль, ОХУ-ын ШУА-ийн Сибирийн салбарын Монгол будда, Төвд судлалын институттэй хамтарсан төрт ёс, төрт эрхзүйн уламжлал, орчин үеийн тулгамдсан асуудлаар эрдэм шинжилгээний хурал тогтмол зохион байгуулдаг ч НББ-ийн мэргэжлийн багш нарыг дотоодын болон ОУ-ын ЭШХ-уудад оролцуулах, санхүү эдийн засаг НББ-ийн чиглэлээр эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах ажил дутмаг байна.

Зөвлөмж:

- НББ-ийн багш нарыг мэргэжлийн болон ТББ-ын үйл ажиллагаанд хамруулах нь хөтөлбөрийн хамтын ажиллагаанд илүү их дэмжлэг болно. /Тухайлбал мэргэжлийн эрх олгох сургалтанд багш хамруулах, мэргэшсэн НББ зэрэгтэй багшийн тоог нэмэгдүүлэх, сургалт, мэргэжлийн байгууллагуудын судалгааны хороодод гишүүнээр ажиллах гэх мэт/
- Хамтын ажиллагаатай сургуулиудтай хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх боломжийн талаарх судалгааг хийх нь хөтөлбөрийн ирээдүй, сургуулийн стратегийн хэрэгжилтэд дэмжлэг болох боломжтой.
- ИЗОИС-ийн бүрэлдэхүүнд байдаг МСҮТ-ийг түшиглэж нярав, тооцоо бодогч гэх мэт мэргэжил эзэмшүүлж, амжилттай суралцаж төгссөн зарим төгсөгчийг бакалаврын хөтөлбөрт дэвшүүлэн суралцуулдаг шаталсан сургалтын хэлбэрийг нэвтрүүлэх боломжийг судалвал хөтөлбөрийг өргөжүүлээд дэмжлэг болж болох юм.

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн жилийн төсөв, зарцуулалтын тайлан
- Нэг суралцагчид ноогдох өртөг зардлын тооцоо
- Сургалтын төлбөрөөс хөтөлбөрт зарцуулагддаг хувь хэмжээ, үр дүнгийн судалгаа
- Хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэгдсэн шинэчлэлт, өөрчлөлтөд зориулсан төсөв, төсвийн зарцуулалт
- Төр, хувийн хэвшлийн дэмжлэг, санхүү түүний зарцуулалтын тайлан

Шалгуурыг хангасан байдал: ХЭСЭГЧЛЭН ХАНГАСАН

Онцлог зүйл/Туршлага:

- Их засаг их сургуулийн зүгээс бүрэлдэхүүн сургуулиудын орлогын төсөв, гүйцэтгэл, орлогын өсөлт, бууралтыг элсэгчдийн тоо, элсэгчдийн тооны өөрчлөлтийн шалтгаан зэрэг үзүүлэлтэд судалгаа дүгнэлт хийдэг.
- Төсөв, төсвийн гүйцэтгэлийг бүрэлдэхүүн сургууль тус бүрээр төлөвлөх ба хяналтыг тавьдаг.
- “Хичээлийн байр, талбайн ашиглалтыг сайжруулж, төсөл хөтөлбөрт хамрагдах, гарааны компани бий болгох замаар орлогоо нэмэгдүүлэх боломжтой” гэж орлогын өсөлтийн төсөөлөл хийдэг.
- Санхүүгийн үйл ажиллагааг хянах зорилгоор санхүүгийн тайландаа шинжилгээ хийдэг. Тухайлбал, өөрийн хөрөнгийн оролцоо, ажлын капитал болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа зэрэг үзүүлэлтээр шинжилгээ хийж дүгнэлт өгдөг.
- Орлогын нэмэлт эх үүсвэр болгож цайны газар, буфет, хэвлэх хувилах үйлчилгээ үзүүлэгч нэгжүүдэд зориулалтын байр талбайг түрээслүүлдэг. Мөн биеийн тамирын болон урлагийн заалыг хувь хүмүүс, ААН, байгууллагуудад төрөл бүрийн тэмцээн, уралдаан, арга хэмжээ, хурлын зориулалтаар түрээслүүлж тодорхой хэмжээний орлого олж уг орлогоос бүрэлдэхүүн сургуулийн захирлуудын шууд захиран зарцуулах мөнгөний эх үүсвэрийг бүрдүүлдэг.
- ХСCloud системийн оюутны бүртгэлийн төлбөрийн хяналтын модулыг сургалтын төлбөр хариуцсан нягтлан бодогч ашиглах боломжтой байдаг. Сургалтын албанаас нэмж болон дахиж судлах, дахин шалгалт өгөх тухай асуудлын улмаас нэмэлт төлбөр төлөх болсон оюутны мэдээллийг татаж үзэх болон бүртгэлтэй оюутнуудаас үндсэн сургалтын төлбөрийн тооцоотой оюутны програмд нэвтрэх эрхийг түр хаах арга хэмжээг авах боломжтой байдаг. Энэ нь дотоод хяналтын горимыг зохих ёсоор биелүүлж байгаагийн илрэл болж байна.
- СЭЗС-ийн жижиг мөнгөн сан /салбар сургуулийн фондны орлого/ жилд дунджаар 60,0 сая төгрөг байдаг. Үүний 26,2 сая төгрөг буюу 43 хувь нь хөрөнгийн түрээсийн орлого, 33,9 сая төгрөг буюу 57 хувь нь шилжиж ирсэн болон жилийн чөлөөнөөс ирсэн оюутны зөрүү кредитийн орлого, шалгалтын орлогоос бүрддэг. СЭЗИС нь нийт орлогын 24 хувийг, харин НББ-ийн хөтөлбөр нь нийт орлогын 8 хувийг бүрдүүлдэг.
- Багш бүрийг сургуулийн төсвөөр суурин компьютерээр хангадаг. Хэвлэх, хувилах төхөөрөмж 3 багшийн дунд нэг ногдохоор хангагдсан. Бүх удирдах ажилтнууд компьютер, хэвлэх, хувилах төхөөрөмжөөр хангагдсан.
- НББ-ийн Даймонд программыг ашиглаж НББ хөтөлж санхүүгийн тайланг бэлтгэж аудит хийлгэдэг бөгөөд сүүлийн 3 жилд “Сэц түшиг” аудитын компаниар санхүүгийн тайланд аудит хийлгэсэн.
- НББ-ийн хөтөлбөрийн багш нарын хөгжлийг дэмжихэд зардал гаргадаг.
 - Багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөр, шагнал урамшууллын зардал
 - Мэргэжил дээшлүүлэхэд олгосон дэмжлэг
 - Ном сурах бичиг, эрдэм шинжилгээний бүтээл хэвлэхэд олгосон зардал

Зардал	2016-2017	2017-2018	2018-2019
Багшийн хөгжлийн зардалд	12,642,600	15,396,000	11,053,800
Багшийн эрдэм шинжилгээ, бүтээлч ажлын зардалд	39,250,000	40,075,000	44,900,000
Нийт	51,892,600	55,471,000	55,953,800
Нийт төсөв	1,667,470,000	1,384,030,000	1,490,232,000
Эрдэм шинжилгээ, багшийн хөгжлийн зардлын нийт зардал эзлэх хувь	3.1%	4.0%	3.8%

- Багш нарын эрдэм шинжилгээ бүтээлч ажлын урамшуулал, дэмжлэгт нэмэгдэл цалин олгодог. Сүүлийн 3 жилд 124,3 сая төгрөгийн нэмэгдэл цалинг НББ-ийн хөтөлбөрийн багш нарт олгожээ.
- Хичээлийн хөтөлбөрийн багц материалыг шинээр боловсруулсан багшид 200000 төгрөгийн нэмэгдэл цалин олгодог.
- Сургалтын төлбөрөөс хөтөлбөрөөр суралцаж буй оюутнуудад сурлагын амжилт, ар гэрийн байдал зэрэг үзүүлэлтүүдийг харгалзан хөнгөлөлт үзүүлдэг уг хөнгөлөлтийг үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөвт суулгадаг.
- НББ-ийн хөтөлбөрийн суралцагчдаас төрийн сангийн буцалтгүй тусамж 7, оюутны хөгжлийн зээлд 8, замын зардлын хөнгөлөлтөд 17 оюутан хамрагдсан. Харин төрөөс шууд санхүүжилт хэлбэрээр НББ-ийн хөтөлбөрөөс ямар нэг санхүүгийн дэмжлэг авдаггүй.
- Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувийг суралцагчийн хөгжилд дараах байдлаар зарцуулдаг. Үүнд:
 - Их Британий магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлөөр магадлан итгэмжлэгдсэнээр сургуулийн төгсөгчдийн дипломыг олон улсад хүлээн зөвшөөрдөг болсон.
 - 3,6-аас дээш голч дүнтэй төгсөгчдийг өөрийн сургуульд үргэлжлүүлэн магистрантурт суралцахад сургалтын төлбөрийн 30%-ийн хөнгөлөлт үзүүлдэг нь мэргэшсэн боловсон хүчин бэлтгэх, төгсөгчдийнхөө нийгмийн асуудалд хувь нэмрээ оруулах, сургуультайгаа байнгын эргэх холбоотой ажиллуулах зэрэг үндсэн хэдэн зорилготой арга хэмжээ болдог.
 - “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нээлттэй өдөрлөг”-ийг жил бүр зохион байгуулж сургууль, ажил олгогч болон төгсөгчдийн эргэх холбоог сайжруулж, ажил олгогч болон төгсөгчдийн хооронд уулзалт танилцуулга хийдэг.
 - “Өглөөний зочин” уулзалт ярилцлагын арга хэмжээгээр салбартаа тэргүүлж буй судлаач болон ажил олгогч бизнес эрхлэгчдийг урьж оролцуулан ажлын байранд очиход юуг анхаарах, хөдөлмөрийн зах зээл чухам ямар ур чадвартай мэргэжилтэн эрэлттэй байгаа болон CV-г хэрхэн бөглөх, ажлын ярилцлаганд ороход юунд анхаарах талаар яриа таниулга хийж зөвлөгөө өгөх ажлыг жилд 2 удаа зохион байгуулж хэвшсэн.
- Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувийг хөтөлбөрөөр суралцагчийн тэтгэлэгт зарцуулдаг.

Тэтгэлэг	2017-2018	2018-2019
Санхүү эдийн засгийн сургуулийн оюутанд олгосон тэтгэлэг	22,730,000	24,468,000
Үүнээс: НББ-н хөтөлбөрийн оюутнуудад олгосон тэтгэлэг	6,819,000	9,787,200
Нийт төсөв	1,384,030,000	1,490,232,000
Санхүү эдийн засгийн сургуулийн оюутанд олгосон тэтгэлэгийн нийт төсөвт эзлэх хувь	1.64%	1.64%

- Нэг суралцагчид ногдох зардлын тооцоог хийдэг. Үүнийгээ жилийн төсөв, төлөвлөгөө боловсруулахад ашигладаг. 2016-2017 онд 2,028,826 төг, 2017-2018 онд 2,135,635 төг, 2018-2019 онд 2,156,932 төг байна.
- Сургалтын төлбөрөөс хөтөлбөрт зарцуулагддаг хувь хэмжээ нь СЭЗС-ийн хувьд 2016-2017 онд 95%, 2017-2018 онд 90%, 2018-2019 онд 94% байна.

Үзүүлэлт	2016-2017	2017-2018	2018-2019
Нэг оюутны дундаж төлбөр	2,120,000	2,260,000	2,280,000

Нэг оюутанд ногдох зардал	2,028,826	2,135,635	2,156,932
Сургалтын төлбөрөөс төсөвт зарцуулагдсан хувь	95%	90%	94%

- Сургалтын үйл ажиллагаанд ашиглах ном, сурах бичгийг худалдан авах, техник тоног төхөөрөмж, програм хангамжийг сайжруулахад сургалтын төлбөрийн орлогоос тогтмол зарцуулдаг.

Анхаарах асуудал:

- Багшийн бие даалт, гэрийн даалгаврын ажилд зарцуулсан цагийн хөлсийг хэрхэн үнэлж тооцдог нь тодорхойгүй.
- Лекц семинарын хичээлийн цагийг бодит цагаар хэмждэг.

Зөвлөмж:

- Багшийн ажлын агуулгад оюутны гэрийн даалгавар, бие даалтын ажлыг чиглүүлэх, шалгах, үнэлэх ажлын хөлсийг хэрхэн тодорхойлдог нь тодорхойгүй байгааг залруулах
- Хичээлийн кредит цагийн агуулгад багтсан ажлуудыг үнэлэх замаар цалин хөлсийг тодорхойлдог болох нь багш нарын тухайн ажилд өгөх ач холбогдлыг нэмэгдүүлж бие даалт, гэрийн даалгаврын хэлбэрээр оюутны мэдлэг, ур чадварыг сайжруулахад эерэг нөлөө үзүүлж болох юм.

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Тандан судалгаа, дүгнэлт, холбогдох материал
- Хийсэн ажил, арга хэмжээ, тайлан, баримт

Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН

Онцлог зүйл/Туршлага:

- НББ-ийн мэргэжлээр элсэлт авдаг сургуулийн тоо тэдгээрээс өөрийн хөтөлбөртэй өрсөлдөхүйц түвшний сургуулийг тандалтын судалгаагаар тодруулдаг.
- Хөтөлбөрт элсэхээр бүртгүүлэгсдийн тоо, элсэгчдийн тоо, элсэж чадаагүй шалтгаан зэргийг тодорхойлох судалгааг хийдэг.
- Жил бүрийн төсөвт маркетинг, сурталчилгааны зардлыг тусгадаг.
- Жил бүр хөтөлбөрийг сурталчилан таниулах үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж мөрдөж, биелэлтэд хяналт тавьж ажилладаг.
- Жил бүр хөтөлбөрийг сурталчилан таниулах үйл ажиллагааны төсвийг баталж гүйцэтгэлд хяналт тавьж ажилладаг бөгөөд жил бүр зарцуулсан зардлын хэмжээ өссөн. 2018-2019 оны хичээлийн жилд 50851,7 мянган төгрөгийг сургуулийн маркетингийн зардалд зарцуулсан байна.
- Хөтөлбөрийн идэвхжүүлэлтийг
 - Сургуулийн вэб хуудас
 - Сургуулийн FB хуудас
 - Боловсролын үзэсгэлэн яармагт оролцох
 - Таниоцуулга материал хэвлэж тараах
 - Телевиз радиогоор сургууль, хөтөлбөрийг сурталчилах, мэдээлэл түгээх
 - Кино театрт мэдээлэл түгээх
 - Шилдэг төгсөгчид урилга олгох, тэтгэлэг, хөнгөлөлт үзүүлэх
 - ЕБС-ын сурагчдад танилцуулга хийх

- ЕБС төгсөгчдийн дунд “Их сунгаа” олимпиад зохион байгуулж тэргүүлсэн сурагчдад урилга олгох
- Хөдөө орон нутагт буюу 21 аймагт сүүлийн 5 жил дараалан оюутан элсүүлэх комисс байгуулж, элсэгчдийн дунд идэвхжүүлэлтийн арга хэмжээ зохион байгуулах зэрэг арга, хэлбэрүүдээр хөтөлбөрийн идэвхжүүлэлтийг хийдэг.

Анхаарах асуудал:

- НББ-ийн мэргэжлийг сурталчилсан, зорилтот бүлэгт тохирсон арга хэмжээг идэвхжүүлэлтийн хөтөлбөрт тусгах талаар анхаарах

Зөвлөмж:

- Маркетингийн идэвхжүүлэлтийг маш сайн явуулдаг ч өмнөх жилүүдийн идэвхжүүлэлтийн хөтөлбөрийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж аль бүс нутагт ямар бүлэгт ямар суваг, хэрэгслийг ашиглаж идэвхжүүлэлтээ хийсэн нь ямар үр дүнд хүрснийг үнэлж НББ-ийн хөтөлбөрт тохирсон онцлогийг идэвхжүүлэлтийн хөтөлбөрт тусгах нь нөөцийг үр ашигтай зарцуулах, идэвхжүүлэлтийн үр дүн улам сайжрахад нөлөөлөх болно.
- Нэгэнт ОУ-ын сургууль учраас гадаадад хөтөлбөрөө экспортлох гадаадын суралцагчийг татахад чиглэсэн маркетингийн идэвхжүүлэлтийг хийхэд анхаарч ажилласнаар зах зээлээ тэлэх, хөтөлбөрийг өргөжүүлэхэд дэмжлэг болох эсэхийг судлаж үзэх нь хөтөлбөрийн ирээдүйн өсөлт хөгжилтөд эерэгээр нөлөөлж болох юм.
- Их засаг лицей сургуулийг төгсөгчдөд НББ мэргэжлийг сурталчилах ажлыг хөтөлбөр, тэнхмийн зүгээс зохион байгуулах нь элсэгчдийн эрэлтэд эерэгээр нөлөөлөх боломжтой.

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжээс гаргасан сонин, сэтгүүл, ном товхимол гарын авлага, цахим мэдээллийн жагсаалт
- Вебсайтын мэдээллийн иж бүрэн байдал, тогтмол ажиллагаа

Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн зорилго, зорилт, хэрэгжилтийн явц байдлын талаар болон удирдлагын шийдвэр зэргийн талаар вэб хуудсанд байршуулдаг.
- ИЗОУИС-ийн үйл ажиллагаа, нийгмийн болон хамтын үйл ажиллагаа, сургалт хүмүүжлийн ажлын талаарх өдөр тутмын мэдээллийг сургуулийн вэб сайт, FB хуудсаар цаг тухайд нь тогтмол мэдээлдэг.
- “Их засаг их сургуулийн төгсөгчдийн холбоо”-ны үйл ажиллагааны хүрээнд төгсөгчдийн чуулга уулзалтыг зохион байгуулж төгсөгчид, ажил олгогчидод хөтөлбөрийн зорилго, зорилтыг танилцуулж хамтын ажиллагааны санамж бичиг гаргасан.
- Багш, оюутнуудтай Сургуулийн ректор, цогцолборын захирал, салбар сургуулийн удирдлага, бүлэг удирдсан багш нарын уулзалтыг зохион байгуулж хөтөлбөрийн зорилго, зорилт, хэрэгжилтийн талаар мэдээлэл танилцуулга хийж, саналыг сонсож хөтөлбөр төлөвлөгөөнд тусгах ажлыг зохион байгуулдаг.
- 1998 оноос Монголын үндэсний радиотой хамтран сургууль болон шинээр гарсан хууль тогтоомжийг сурталчилах ажилд хувь нэмрээ оруулж “Их засаг сургуулиар сонин юутай байна” “Мөнх тэнгэрийн хүчин дор” 20-30 минутын нэвтрүүлгийг давталттайгаар сард 4 удаа явуулж ирсэн.

- Зууны мэдээ, Өдрийн мэдээ сонинд сард 4 удаа ИЗОИС-ын талаарх мэдээ мэдээллийг нийтлүүлэх замаар хөтөлбөрийн тухай мэдээллийг олон нийтэд түгээдэг, хамтран ажиллах гэрээтэй.
- Сургалтын нэгдсэн албанаас багш оюутнуудын оролцоотойгоор ИЗОИС, мэргэжил сурталчилах нэлттэй өдөрлөгийг ЕБС-ын суралцагчдын дунд жил бүр зохион байгуулдаг.
- МИДСК, ХИДСХ-ны шугамаар зохион бхйгуулдаг боловсролын үзэсгэлэн яармагт оролцож сургууль, хөтөлбөрийн талаарх мэдээллийг түгээдэг.
- 2010 оноос TV8 теледидээр “Эрдмийн түлхүүр” нэртэй 7 хоног тутмын нэвтрүүлэг, 2009 оноос NTV, TV9, 25-р суваг, TV5, Боловсрол телевиз болон Монголын үндэсний радио, Зууны мэдээ,Өдрийн сонин, Үнэн, Үндэсний шуудан, МОНЦАМЭ зэрэг өдөр тутмын сонинд сургуулийн танилцууга нийтлүүлэх болсон.
- Жил бүр уламжлал болгон Super student төслийг салбар сургуулиудын оюутны дунд 7 дахь жилдээ 2 үе шаттайгаар зохион байгуулж шалгарсан оюутныг гадаадын ИДС-д тэтгэлэгтэйгээр суралцуулдаг.
- ИХ засаг их сургуулийн дэргэд FM радио, телевиз байгуулж ажиллуулж байгаа нь сургууль, хөтөлбөр ийг олон нийтэд сурлалчилах талаараа бусад ИДС-иас илүү гэдгийг харуулдаг.

Анхаарах асуудал:

- байхгүй

Зөвлөмж:

- Оюутны сургалтын төлбөрийн нэмэгдэл, төлбөрийн зарцуулалтын талаарх мэдээллийг оюутанд нээлттэй түгээх

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Элсэлтийн бодлого, дүрэм журам
- Элсэгчдийн ЕШ-ын дундаж оноо, хүсэлт гаргасан болон элссэн суралцагчдын харьцаа
- Шинэ суралцагчдад зориулсан мэдээлэл, гарын авлага
- Гадаад оюутны элсэлтийн тоо

Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН

Онцлог зүйл/Туршлага:

- Их засаг ОУИСургуулийн Санхүү эдийн засгийн сургуулийн нягтлан бодох бүртгэлийн хөтөлбөрөөр элсэгчидэд зориулсан дараах дүрэм журмыг баримталдаг. Үүнд: Оюутан элсүүлэх журам, Элсэгчидэд танилцуулга хийх журам, Элсэгчидийг бүртгэх журам. Эдгээрээс Оюутан элсүүлэх журам нь сүүлийн 3 жилд өөрчлөгдөн шинэчлэгдсэн. Өөрчлөлтүүд нь БСШУСЯ болон ИДСКонсорциумаас ирсэн шийдвэр болон ИЗОУИС-ийн шинэ элсэгчидэд зориулсан тэтгэлэгт хөтөлбөрийн ангилал, төрөл нь нэмэгдэж ирсэнтэй холбоотой байв.
- Элсэгчдийн ЕШ-ийн оноо сүүлийн 2 жилийн байдлаар, 2017-2018 оны хичээлийн жилд 495 байсан бол 2018-2019 оны хичээлийн жилд 511 болж өсчээ.
- Элсэгчдэд зориулж “Их сунгаа” сургалт, “Нээлттэй хаалга”-ны өдөрлөг, TV нэвтрүүлгүүд, уулзалт, семинар, үзэсгэлэн яармаг, хэвлэмэл материалууд гаргах зэрэг олон ажлуудыг зохион

байгуулдаг. Шинэ оюутанд зориулсан гарын авлага хэвлэн тараадаг. Шинэ элсэгчдэд зориулж “Оюутны үйлчилгээний төв” ажиллан тогтмол зөвлөгөө өгдөг.

- Гадаад оюутан элсүүлэн суралцуулах бодлогын бичиг баримтыг Их засаг ОУИСургуулийн Ректорын 2014.09.03-ны өдрийн А/59 тоот тушаалаар баталсан журмыг баримталдаг. Одоогоор тус хөтөлбөрөөр гадаад оюутан суралцдаггүй.

Анхаарах асуудал:

- НББүртгэлийн хөтөлбөрөөр гадаад оюутан элсүүлэн суралцуулах тал дээр анхаарах

Зөвлөмж:

- Оюутны гарын авлагыг баяжуулан гаргах эсвэл онлайн гарын авлага гаргах боломжтой.
- НББ хөтөлбөрөөр гадаад оюутан элсүүлэн суралцуулах.

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Зөвлөх, хөгжүүлэх үйлчилгээний төлөвлөгөө, тайлан
- Сэтгэл ханамжийн судалгаа, баримт материал
- Зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тайлан мэдээ.
- Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын тайлан мэдээ

Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН

Онцлог зүйл/Туршлага:

- Оюутныг зөвлөн хөгжүүлэхэд чиглэсэн дараах дүрэм журмыг мөрдөн ажилладаг. Үүнд:
 - ИЗОУИС-ийн Оюутны хөгжлийг дэмжих журам
 - Амжилт ахиулах хөтөлбөр
 - ИЗОУИС-ийн оюутан сурагчдад Цогц боловсрол, өв тэгш хүмүүжил олгох нэгдсэн хөтөлбөр
 - ИЗОУИС-ийн оюутнуудад сургалтын төлбөрийн хөнгөлөлт эдлүүлэх журам
 - ИЗОУИС-ийн 18 насанд хүрээгүй оюутанд үйлчилгээ үзүүлэх журам
 - ИЗОУИС-ийн хөгжлийн бэрхшээлтэй оюутанд үйлчилгээ үзүүлэх журам
 - Хөгжлийн бэрхшээлтэй оюутны үнэлгээнд шударга хандах журам
 - Хөдөлмөрт зуучлах журам
 - Оюутныг цагаар ажиллуулах журам
- Оюутныг зөвлөн чиглүүлэх үйл ажиллагаа нилээд хэд хэдэн чиглэлээр хөгжсөн. Үүнээс оюутан, суралцагчдад “ЦОГЦ БОЛОВСРОЛ” олгох хөтөлбөрийг 2009 оноос эхлэн хэрэгжүүлсэн нь илүү үр дүнтэй ажил болсон. Багш нар нь тус хөтөлбөрийн дагуу төлөвлөгөөтэй ажилладаг ба сургуулийн удирдлагын баг үр дүнг нь нарийн тооцож ахиц дэвшлийг нь тооцдог. Төгсөгчид, ажил олгогчдын уулзалтын үеэр “ЦОГЦ БОЛОВСРОЛ” олгох хөтөлбөр их үр дүнтэй ажил гэдэг нь баталгаажсан.
- “Амжилт ахиулах хөтөлбөр”, “Дундчуудтай ажиллах хөтөлбөр” зэргийг хэрэгжүүлдэг. Оюутантай ажиллах нэг өдрийг гаргаж ажилладаг ажил тогтворжсон. Оюутантай ажилласан эдгээр ажлын үр дүнг “Ажлын гүйцэтгэлийн үнэлгээний журам”-ын дагуу багш өөрийн үнэлгээний тайландаа тусган хамгаалдаг, хэлэлцдэг хурлын протоколтой.

- Оюутнаас сэтгэл ханамжийн судалгааг жилд нэг удаа авдаг. Сүүлийн 3 жилийн судалгааны тайлан байна. Оюутнаас авах санал асуулга нь багшийн заах арга, хандлагын үнэлгээ, Сургалтын орчин, Оюутны сэтгэл ханамж гэсэн 3 чиглэлээс бүрдсэн.
- Оюутны дунд сургалт-судалгаа-давтлага, урлаг, спортын олон төрлийн арга хэмжээг зохион байгуулдаг. Үүнд:
 - Хувь хүний чадавхийг хөгжүүлэх хөтөлбөр
 - “SUPER STUDENT” хөтөлбөр /оюутан солилцоог үр дүнтэй явуулдаг./
 - Оюутны ЭШ хурлыг тогтмол үе шаттай зохион байгуулдаг.
 - Төрөл бүрийн спортын тэмцээн
 - Урлагын их наадам
 - Эдийн засгийн нээлттэй форум
 - НББ-ийн олимпиад
 - Илтгэх урлаг, мэтгэлцээний клуб гэх мэт олон ажлыг зохион байгуулсан сүүлийн 3 жилийн ажлын төлөвлөгөө, тайлантай танилцав.

Анхаарах асуудал:

- НББ-ийн хөтөлбөрийн оюутнуудын эрдэм шинжилгээ, судалгааны ажилд илүү олноор нь оролцуулах

Зөвлөмж:

- НББ-ийн хөтөлбөрийн оюутнуудын эрдэм шинжилгээ, судалгааны ажлын амжилтыг ахиулах

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Оюутны клубын зохион байгуулсан арга хэмжээ, тайлан мэдээ
- Суралцагчийн гүйцэтгэсэн сайн дурын ажлын үнэлгээ, урамшуулал
- Цагийн ажил, үндсэн ажилд зуучилсан төгсөгч, оюутны тоон мэдээлэл.
- Олимпиад, уралдаан тэмцээнд оролцсон суралцагчийн тоо, үр дүнгийн мэдээлэл
- Урамшуулал, тэтгэлэг хөнгөлөлтөд хамрагдсан суралцагчдын тоо

Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН

Онцлог зүйл/Туршлага:

- Оюутнуудын санаачлага, удирдлага доор 4 клуб ажилладаг. Үүнд: Банкир клуб, Залуу судлаач клуб, Customs edu клуб, Young life клуб. Эдгээр клубууд нь үйл ажиллагаагаа төлөвлөж, тайлганадаг.
- Оюутныг бүлгийн системээр зохион байгуулдаг. Бүлэг бүр 7 хоногт зохион байгуулсан үйл ажиллагааны тайланг хийж деканд танилцуулан үнэлүүлдэг ажил тогтворжсон. Үүнд: Мэндчилгээ хийх, сайн үйлийн аян, бид багштайгаа, аз жаргалтай анги, тэмдэглэлт өдрийн ханийн сонин, таслалтгүй хамт олон, гадаад үг цээжлэх өдөр, АХА, талархалын аян, багшдаа баярлалаа өдөрлөг гэх мэт олон ажлыг зохион байгуулж тайлагнадаг. Улиралд нэг удаа эдгээр үйл ажиллагааг нэгтгэн самбарын бүртгэлээр уралдуулан шилдэг бүлгийг тодруулан өргөмжлөл үнэ бүхий зүйлээр шагнадаг. Шагналын төрөл янз бүр байдаг тухайлбал спорт зааланд тоглох цаг өгөх гэх мэт. Оюутны үйл ажиллагаанд зориулсан төсөв хөрөнгийг сургуулийн зүгээс хангалттай сайн олгодог. Энэ хичээлийн жилд оюутны үйл ажиллагаанд 6 сая төгрөг төсөвлөсөн байна.

- Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийг байгуулан ажиллаж байна. Сонгино хайрхан дүүргийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэстэй хамтран ажилладаг. ИЗСЭЗС-аас цагийн болон үндсэн ажилд зуучилсан тоо: \НББ хөтөлбөрөөр\ 2017-2018 оны хичээлийн жилд 18 оюутан, 2018-2019 оны хичээлийн жилд 21 оюутныг түр болон байнгын цагийн ажилд зуучилсан байна. Ажлын төрөл нь дэлгүүр, барилгын компанид, караоке, хөнгөн үйлдвэр, ресторани зэрэг аж ахуйн нэгж байгууллагад цагийн ажил хийж байна. “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нээлттэй өдөрлөг”-ийг жил бүр зохион байгуулснаар сургууль, ажил олгогч болон төгсөгчдийн эргэх холбоог сайжруулж, ажил олгогч болон төгсөгчдийн хооронд уулзалт танилцуулга хийж өгснөөр төгсөгч өөрийн ажиллахыг хүсч буй салбараа сонгох, өөрийнхөө мэргэжлийн үнэ цэнийг улам ойлгох зэрэг боломж олгохоос гадна ажил олгогчдын шаардлагыг мэдэрч ойлгох боломжтой болдог. “Өглөөний зочин” уулзалт ярилцлагыг жилд 2 удаа зохион байгуулж салбартаа тэргүүлж буй судлаач болон ажил олгогч бизнес эрхлэгчдийг урьж оролцуулан ажлын байранд очиход юуг анхаарах, хөдөлмөрийн зах зээл чухам ямар боловсон хүчнийг хүсч байгаа болон CV бөглөх, ажлын ярилцлаганд ороход юунд анхаарах талаар яриа таниулга хийж зөвлөгөө өгүүлдэг.
- Мэргэжлийн олимпиадад оюутнуудыг оролцуулдаг. Жишээ нь ЭЗ онолын, Статистикийн, Менежментийн олимпиадиудад оролцсон байна.
- Оюутнуудыг урамшуулал, тэтгэлэг, хөнгөлөлтөд хамруулдаг. Төрөл нь Чингэс хааны тэтгэлэг, нэг гэр бүлийн олон хүүхэд суралцахад олгодог тэтгэлэг, ихэр хүүхдүүдэд олгох тэтгэлэг, гэр бүлийн хөнгөлөлт, уралдаан тэмцээнд амжилт үзүүлсэн тохиолдолд олгох, 3,6-аас дээш голчтой оюутан магистрт 30% хөнгөлөх, амьжиргааны түвшингийн, насанд хүрээгүй оюутан дотуур байранд суухад үзүүлэх хөнгөлөлт, баруун 7 аймгийн оюутнууд дотуур байранд үнэ төлбөргүй суралцах хөнгөлөлт, хагас өнчин оюутанд 10% хөнгөлөлт үзүүлдэг гэх зэрэг олон урамшуулал, тэтгэлэг хөнгөлөлтөнд хамруулдаг. 2018-2019 оны хичээлийн жилд НББ-ийн мэргэжлийн оюутнуудаас 16 оюутан хамрагдсан байна.

Анхаарах асуудал:

- Нягтлан бодох бүртгэл хөтөлбөрөөр суралцагчидад зориулсан мэргэжлийн клуб байгуулахад анхаарах
- Цаашдаа НББ-ийн мэргэжлийн олимпиад 3-4 ангид нь суралцах оюутнуудыг бэлтгэн оролцуулах

Зөвлөмж:

- Клубуудын үйл ажиллагаанд НББ хөтөлбөрийн оюутнуудын оролцоог нэмэгдүүлэх
- НББ мэргэжлийн улсын олимпиадад оюутнуудыг бэлтгэн оролцуулах

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Илрэл нотолгоо:

- Суралцагчийн шилжилт хөдөлгөөний судалгаа
- Багц цагийн дүйцэл, шилжилт хөдөлгөөний судалгаа, дүрэм журам

Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН

Онцлог зүйл/Туршлага:

- ИЗОУИС-ийн ректорын 2012 оны 03 сарын 26-ны 1/237 тоот тушаалаар батлагдсан “Шилжилт хөдөлгөөний журам”-ын дагуу суралцагчийн эрх ашигт нийцүүлэн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэдэг.
- НББ хөтөлбөрийн хувьд 2017-2018 оны хичээлийн жилд жилийн чөлөөнөөс ирсэн оюутны тоо байхгүй, жилийн чөлөө авсан оюутны тоо байхгүй, бусад сургуулиас шилжин ирсэн нэг,

сургууль дотроо шилжиж анги солисон нийт оюутны тоо байхгүй байна. Хичээлийн жилд захирлын 4 удаагийн шилжих хөдөлгөөний тушаал гарсан байна.

- 5 жилийн хугацаатай шилжих хөдөлгөөний төрлөөр харьцуулсан судалгаа хийсэн байна.

Анхаарах асуудал:

- Суралцагчийн шилжилт хөдөлгөөний шалтгаан, тоон үзүүлэлтэд хийсэн судалгаа байхгүй.
- Шилжин хөдөлгөөний журманд хэдэн кредитийг дүйцүүлэн хүлээн зөвшөөрөх заалт байхгүй.

Зөвлөмж:

- Суралцагчийн шилжилт хөдөлгөөн харьцангуй бага байгаа боловч цаашдаа шалтгаан, тоон үзүүлэлтэд хийсэн судалгааны үр дүнг тооцож байх
- Шилжин хөдөлгөөний журманд хэдэн кредитийг дүйцүүлэн хүлээн зөвшөөрөх заалтыг нэмж оруулах.

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

- Төгсөлтийн баримт бичгийн загвар
- Төгсөлтийн баримт бичгийг олгох дүрэм журмын хэрэгжилтийн байдал

Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН

Онцлог зүйл/Туршлага:

- 2015.11.11 өдрийн А/187 тоот тушаалаар батлагдсан Сургалтын журмын 4.11.3-д төгсөлтийн бичиг баримтын загварыг тусган өгч түүний дагуу Төгсөлтийн баримт бичгийг боловсруулан олгодог байна.
- Төгсөлтийн баримт бичгийг олгох дүрэм журмын хэрэгжилтийн байдал сайн.

Анхаарах асуудал:

- Байхгүй

Зөвлөмж:

- Байхгүй

5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн хүний нөөцийн цогц бодлогын баримт бичиг, хэрэгжилтийн тайлан
- Доктор зэрэгтэй багш нарын эзлэх хувийн жин, судалгаа /сүүлийн 5 жилээр/
- Багш, суралцагчдын тооны зохистой харьцааны судалгаа /сүүлийн 5 жилээр/
- Багшийн албан тушаалын зэрэглэлийн ангилалд тавигдах шаардлагад нийцсэн байдлын судалгаа.
- Багшийн цагийн ачаалал тооцсон судалгаа
- Багш нарт олгосон урамшууллын судалгаа

Шалгуурыг хангасан байдал: ХЭСЭГЧЛЭН ХАНГАСАН

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн хүний нөөцийн асуудлаар дараах дүрэм, журмыг баримталдаг. Үүнд:

- ИЗОУИС-д багш, ажилтан шалгаруулж авах журам
 - Багшийн албан тушаалын зэрэглэлийн шалгуур үзүүлэлт
 - Багшийн албан тушаалын зэрэглэл олгох журам
 - Багш, ажилчдын хөгжлийг дэмжих журам
 - ИЗОУИС-ийн Багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээний журам зэрэг хамаарагддаг. Мөн эдгээр дүрэм журмын хэрэгжилтийг тайлагнан үр дүнг нь тооцдог байна.
- Доктор зэрэгтэй багш нарын эзлэх хувийн жин, судалгааг 5 жилээр гаргасан байна. СЭЗСургуулийн хэмжээнд 30 багш ажиллаж байгаагаас 9 доктор ажиллаж байна. Харин Нягтлан бодох бүртгэлийн 13 багш ажиллаж байгаагаас 4 нь доктор, 3 нь докторонтурт суралцаж байна.
 - Багш, суралцагчдын тооны зохистой харьцааны судалгааг сүүлийн 2 жилээр хийсэн ба 2017-2018 оны хичээлийн жилд нэг багшид 5 оюутан ногдож байсан бол 2018-2019 оны хичээлийн жилд нэг багшид 8 оюутан ноогдож байна. Ерөнхийдөө оюутны тоо цөөн боловч сүүлийн жилд элсэн суралцсан оюутны тоо өссөн байна.
 - ИЗОУИС-ийн ректорын 2012.03.26-ны өдрийн 1/237 тоот тушаалаар батлагдсан “Багшийн албан тушаалын зэрэглэл олгох журам”-ыг хэрэгжүүлдэг. Энэ журмын дагуу СЭЗС-иас сүүлийн 5 жилд багш зэрэглэлээс ахлах багш руу ахисан хүний тоо 7, дэд профессор 1 байна. Багш ажилчдын ёс зүйн дүрмийн дагуу зэрэглэл бууруулж болдог. НББ-ийн хөтөлбөрийн багш нараас ийм шийтгэлийн арга хэмжээ авхуулсан багш байхгүй байна.
 - Багшийн цагийн ачаалалыг жилд А,В,С нийлээд 1480 цаг байхаар төлөвлөн тооцдог. Багшийн 5 зэрэглэлд тус ачаалалыг журмаар тооцон ажилладаг. Багшийн цагийн ачаалалын судалгааг гарган харахад багш долоо хоногт 14-18 цагийн хичээл заадаг.
 - Багш нарт олгосон урамшууллын судалгаа: Багш доктор хамгаалахад нэг сарын цалинтай чөлөө олгодог, доктор хамгаалсан хүнд 60 цагтай тооцох хэмжээний мөнгөн тусламж үзүүлдэг. 5 жилийн хугацаанд тэнхимийн Т. Ганхүү, Г.Наранбаатар нар доктор хамгаалсан. Энэ хугацаанд нийт сургуулиас 6419600 төгрөгийн мөнгөн тэтгэмж авсан байна. Мөн эрдэм шинжилгээ, судалгааны дэмжлэгийг олон багшид олгосон байна.

Анхаарах асуудал:

- Олон журам, дүрэм байгаа боловч ИЗОУИС-ийн хүний нөөцийн цогц бодлогын бичиг баримт байхгүй.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн хүний нөөцийн цогц бодлогын баримтыг тусгайлан боловсруулах
- Багшийн цагийн ачаалалыг бусад сургуулийн кредит системтэй харьцуулан судалгаа хийх

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Илрэл нотолгоо:

- Багшлахуйн ур чадвар, судалгааны ур чадвар, суралцах хэрэгцээг тодорхойлсон судалгаа, судалгааны дагуу хийсэн ажлын баримт
- Төлөвлөгөө, тайлан
- Багшийг гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлж чадавхжуулсан судалгаа.

Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН

Онцлог зүйл/Туршлага:

- Багшийн хөгжлийг дэмжих төвийг ИЗОУИС-ийн ректорын 2013 оны 09 сарын 06 өдрийн 1/37 тоот тушаалаар зохион байгуулсан ба “Багшийн хөгжлийг дэмжих журам”-ыг батлан мөрдөж байна. Тухайлбал, “Багшийн мэргэжил дээшлүүлэх институт”-ын захирал Д.Сүрэнчимэг “Багшийн хөгжил заах арга зүй” сэдвээр бүх багш нарт илтгэл тавьсан. Сар бүр сургалт заах арга зүйн семинарыг зохион байгуулан явуулдаг тайлан байна. Багшлахуйн ур чадвар, судалгааны ур

чадвар, багшийн хөгжих хэрэгцээг хүн бүрээр төлөвлөн баталж **БАГШИЙН ХӨГЖЛИЙН ДЭВТЭР** хөтлөн ажиллаж эцэст нь багш хийсэн ажлаараа өөрийн үнэлгээний тайлан бичиж ИЗОУИС-ийн Багшийн ажлын үнэлгээний журмын дагуу ректорын тушаалаар батлагдсан зөвлөлөөр орж хамгаалдаг.

- Багшийг гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлж чадавхжуулах ажлыг тодорхой түвшинд зохион байгуулж иржээ. 2013 оноос хойш Мэргэшсэн НБ-ын эрх олгох сургалтанд 1 багш, Дотоод аудитын сургалтанд 2 багш, “НББ-ийн шинэчлэлт, өөрчлөлт, цаашдын чиг хандлага” /Сангийн яамнаас зохион байгуулсан/ сургалтанд 3 багш, НББ-ийн хуулийн шинэчлэлийн сургалтанд 1 багш, 2018 онд БНСУ-д богино хугацааны мэргэжил дээшлүүлэх сургалтанд 5 багш хамрагдсан байна. Сертификат, эрхийн бичигтэй танилцав. Зардлыг сургуулиас төлсөн баримттай танилцав.

Анхаарах асуудал:

- Эрдмийн зэрэг цолтой НББ-ын мэргэжлийн багшийн тоог нэмэгдүүлэх

Зөвлөмж:

- Мэргэшсэн НБ-ын эрх олгох сургалтанд багш нарын түлхүү суралцуулах

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Боловсролын болон шинжлэх ухааны шинэ туршилт, инноваци, ашигтай загвар, патентийн тоон судалгаа
- Бодлогын баримт бичиг, дүрэм журам
- Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, судалгааны ажлын тайлан мэдээ, хөтөлбөрт тусгагдсан байдал
- Нийтлэгдсэн бүтээл, судалгааны ажил, эшлэгдсэн тоо
- Зарцуулсан төсөв, тайлан

Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН

Онцлог зүйл/Туршлага:

- Салбар сургууль бүр дээр Инновацийн төвийг байгуулан ажиллаж байна. НББ хөтөлбөрийн оюутнууд инновацийн төвөөр дамжуулан сүүлийн 5 жилд 6 төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэн ажиллаж байна. 3 багш өөрийн хийсэн судалгааны ажлаараа патент авсан. Мөн
 - o Процессийн үйлдвэрлэл
 - o Амирлан органик савангийн үйлдвэр
 - o 3D принтын үйлдвэрийн төслийн багш оюутны хамтарсан баг бичиж оюуны өмчийн эрх авч үйлдвэрлэлийг явуулж байна.
- Багшийн эрдэм шинжилгээ, судалгааны ажилтай холбоотой дүрэм журам:
 - o Эрдмийн зөвлөлийн ажиллах журам
 - o Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнг дээшлүүлэх зарим арга хэмжээний тухай Ректорын тушаал
 - o ИЗОУИС-ийн эрдэм шинжилгээний их семинар зохион байгуулах журам
 - o Хүндэт доктор, хүндэт профессор цол олгох журам зэргийг хэрэгжүүлэн мөрддөг.
- Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, судалгааны ажлын тайлан мэдээтэй танилцахад, 2016-2019 онд 4 багш 5 төсөл, хөтөлбөр дээр ажилласан ба тэдний 2 нь сургуулийн дотоод төсөл, 1 нь байгууллагын захиалгат төсөл, 2 нь санхүүгийн зөвлөх үйлчилгээ байв.
- 2015-2019 онд хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нараас 4 сурах бичиг, 14 гарын авлага бодлого дасгалын хураамж, 10 эрдэм шинжилгээний илтгэл тавьсан байна.
- Зарцуулсан төсөв, тайлан

Зардал	2016-2017	2017-2018	2018-2019
Багшийн хөгжлийн зардалд	12,642,600	15,396,000	11,053,800

Багшийн эрдэм шинжилгээ, бүтээлч ажлын зардалд	39,250,000	40,075,000	44,900,000
Нийт	51,892,600	55,471,000	55,953,800
Нийт төсөв	1,667,470,000	1,384,030,000	1,490,232,000
Эрдэм шинжилгээ, багшийн хөгжлийн зардлын нийт зардал эзлэх хувь	3.10%	4.00%	3.80%

Анхаарах асуудал:

- Гадаадын болон улсын хэмжээний **төсөл, хөтөлбөрт** ажиллах багшийн тоог нэмэгдүүлэх
- Олон улсын болон улсын хэмжээний ЭШ хуралд илтгэл тавьж, өгүүлэл хэвлүүлэх тоог нэмэгдүүлэх

Зөвлөмж:

- НББ-ийн хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нар гадаадын болон улсын хэмжээний төсөл, хөтөлбөрт ажиллах
- Багш нар олон улсын болон дотоодын ЭШ-ны хуралд түлхүү оролцох, гадаадын нэр хүнд бүхий ЭШ-ны сэтгүүлд өгүүлэл судалгааны ажил нийтлүүлэх, бүтээлд эшлэгдсэн тоог өсгөх

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Илрэл нотолгоо:

- Багшийн өөрийн үнэлгээний тайланг үнэлэх дүгнэх журам, хэрэгжилтийн тайлан
- Багшийн өөрийн үнэлгээний тайлан
- Хөндлөнгийн үнэлгээний дүн
- Багшийн үнэлгээний дагуу авч хэрэгжүүлсэн ажил арга хэмжээний тайлан мэдээ
- Багшийн хавтас

Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН

Онцлог зүйл/Туршлага:

- Багш бүр хичээлийн жилд сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр өөрийн хөгжлийн төлөвлөгөөг батлуулан “Багшийн хөгжлийн дэвтэр” хөтлөн жилийн эцэст ректорын 2009 оны 12 сарын 01-ний өдрийн 1/91 тоот тушаалын 1-р хавсралаар баталсан “ИЗОУИС-ын Ажлын гүйцэтгэлийн үнэлгээний багийн гишүүдийн АГҮнэлгээг тооцож хариуцлага хүлээлгэх” журмын дагуу тайлагнан хамгаалдаг. Хамгаалалт хийсэн хурлын протокол жил бүрээр байв.
- ИЗОУИС-ын хэмжээгээр дээрхи үнэлгээ нь сургууль бүрээр үр дүнг нь тооцон байр эзлүүлээд оны шилдэг сургууль шалгаруулж мөнгөн шагнал өгдөг ба багшийг бас урамшуулдаг. Тушаалтай танилцав.
- Багш бүр заадаг хичээлийн хавтас, оюутантай ажиллах хавтастай, ЭШ хавтас зэргийг хөтлөдөг.

Анхаарах асуудал:

- байхгүй

Зөвлөмж:

- Багшийн сэтгэл ханамжийн судалгааг хийж ажлын ачаалал, сэтгэл ханамжийг судалж цаашдын үйл ажиллагаандаа тусгах
- Багшийн ажлын гүйцэтгэлд лекц болон семинарын хичээлийг ижил цагаар тооцож байгааг цаашдаа судлан анхаарах. Бусад сургууль кредитээр тооцдог тогтолцоотой харьцуулсан судалгаа хийх.

6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтын удирдлага, зохион байгуулалтын схем
- Чанарын дотоод баталгаажуулалтын тогтсон бодлого, журам, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, үнэлгээ
- Чанарын дотоод баталгаажуулалтад хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангах чиглэлээр хийсэн ажлын тайлан мэдээ

Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН

Онцлог зүйл/Туршлага:

- Сургуулийн Ажлын гүйцэтгэлийн үнэлгээний алба нь хөтөлбөрт оролцогч болон сонирхогч талуудын саналыг тусгах, судалгаа авах чиглэлээр Хөтөлбөрийн багш нартай хамтарч ажилладаг. Харин оролцогч болон сонирхогч талаас судалгааг авах ажлыг бие даан зохион байгуулдаг. Гэхдээ хөтөлбөр хариуцсан тэнхим, сургуулиас оюутны сэтгэл ханамжийн судалгааг бие даан авч ажилласан байна.
- Чанарын дотоод баталгаажуулалтыг батлагдсан журам, хөтөлбөр, төлөвлөгөөний хүрээнд хийж байна.
- Багш, төгсөгчдийн эргэх холбоо сайн.

Анхаарах асуудал:

- Оюутнуудаас хэт олон давтамжтайгаар олон субъектээс олон төрлийн судалгаа авч байгаа нь судалгаа бөглөхөөс оюутнуудыг залхаах байдалд хүргэж болзошгүйг анхаарах.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талуудаас судалгааг авахдаа зөвхөн цаасан хэлбэрээр бус онлайн, фокус группийн ярилцлага гэх мэт судалгааны олон талт аргыг хэрэглэх.
- Оюутнуудаас семестерийн эсвэл хичээлийн жилийн эцэст нэгдсэн нэг судалгааг авах. Уг судалгааг онлайн-аар хэлбэрээр авах боломжийг судлах.

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна..

Илрэл нотолгоо:

- Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа, дүгнэлт, үр дүн
- Төгсөгчдийн карьер өсөлтийн судалгаа, дүгнэлт, үр дүн
- Төгсөгчдийн ажлын байраар хангагдах хүртэлх хүлээх хугацааны судалгаа, дүн шинжилгээ
- Оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгаа, дүн шинжилгээ /Ажил олгогч, мэргэжлийн холбоод, төгсөгч гэх мэт/
- Хөтөлбөрийн үр дүнгийн судалгаа

Шалгуурыг хангасан байдал: ХЭСЭГЧЛЭН ХАНГАСАН

Онцлог зүйл/Туршлага:

- Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа, Төгсөгчдийн карьер өсөлтийн судалгаа, Төгсөгчдийн ажлын байраар хангагдах хүртэлх хүлээх хугацааны судалгаа, Ажил олгогчдын судалгааг тус бүрд нь нарийвчилан авсан байна.
- Төгсөгчдөөс авсан судалгааны үр дүнд шинжилгээ хийж сургалтандаа тусган ажилласан байна. Тухайлбал, НББ-ийн мэдээллийн програм суурилуулах, оюутнуудын НББ-ын анхан шатны баримттай ажиллах чадварыг дээшлүүлэх гэх мэт.
- НББ-ын хөтөлбөрийн төгсөгчдийн тоо 2005-2014 оны хооронд 1502 нягтлан бодогч бэлтгэн гаргасан. Сүүлийн 5 жилийн байдлаар авсан судалгааны дүнгээр, төгсөгчдийн 11.0 хувь буюу 165 төгсөгч өөрийн ажиллаж буй ажилдаа албан тушаал ахисан байна.
- Төгсөгчдийн холбоо төгсөгчдөөсөө судалгааг жил бүр авдаг.
- Талуудын Оролцогч болон сонирхогч талуудын санал, асуулгын дүнг нэгтгэсэн арга зүй нь хангалттай сайн байна.

Анхаарах асуудал:

- Судалгаанд хамрагдсан субъектуудын төлөөлөх чадвар бүхий тоо хэмжээнд анхаарах.
- Нийт төгсөгчдийн 80.0 хувь нь ажлын байраар хангагдсан хэдий ч төгсөгчдийн ажлын байраар хангагдах хугацаа 2 жил байна.
- Оюутныг ажлын байраар хангахад чиглэсэн нэгж ажиллаж мөн Сонгинохайрхан дүүрэгтэй хамтран ажиллаж хэдий ч хүртээмжийг цаашид нэмэгдүүлэх.

Зөвлөмж:

- Төгсөгчдийн ажлын байраар хангагдах хүртэлх хүлээх хугацааны судалгаа нь 2 жил байгаа тул ажлын байраар хангагдах, ажлын байраар зуучлах ажлыг улам сайжруулах.
- Төгсөгчдийн мэргэжлээрээ ажиллах хувь хэмжээг нэмэгдүүлэхэд чиглэсэн мэргэжлийн тусгайлсан сургалтуудыг сургууль дээрээ зохион байгуулах, богино хугацааны эрчимжүүлсэн курс зохион байгуулах гэх мэт ажлуудыг зохион байгуулах.

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

-Магадлан итгэмжлэх байгууллагаас гаргасан дүгнэлт, зөвлөмж, шаардлага, магадлан итгэмжилсэн шийдвэр

-Хөтөлбөрөөр төгсөгчдийг мэргэжлийн салбарт хүлээн зөвшөөрсөнийг нотлох баримт бичгийн судалгаа /мэргэжлийн зэрэг, эрхийн үнэмлэх гэх мэт/

-Мэргэжлийн холбоодтой хамтран ажилласан ажлын тайлан мэдээ.

-Дотоод, гадаадын дараагийн шатны хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцаж буй төгсөгчдийн хувь

Шалгуурыг хангасан байдал: БҮРЭН ХАНГАСАН

Онцлог зүйл/Туршлага:

- Англи улсын Магадлан итгэмжлэлийн Зөвлөлийн байгууллагын магадлан итгэмжлэлд орж магадлан итгэмжлүүлсэн.
- ISO гэрчилгээтэй.
- Монголын их, дээд сургуулиудын консорциумаас хувийн их, дээд сургуулиудын шилдэг сургуулийн шагнал авсан.
- Хөтөлбөрийн нийт төгсөгчдийн 11.0 хувь нь гадаадын их, дээд сургуульд түвшин ахиулах сургалтанд хамрагдсан.

Анхаарах асуудал:

- байхгүй

Зөвлөмж:

- Цаашид ACBSP магадлан итгэмжлэлд орох зорилт тавьж ажиллах

ДҮГНЭЛТ

Их Засаг их сургуулийн Санхүү Эдийн Засгийн Сургуулийн “Нягтлан бодох бүртгэл” бакалаврын хөтөлбөрийн ерөнхий үнэлгээ БҮРЭН ХАНГАСАН. Нийт 26 шалгуурын 21 нь БҮРЭН ХАНГАСАН, 5 шалгуур нь ХЭСЭГЧЛЭН ХАНГАСАН.

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаагүй (0)	Үндэслэл, шалтгаан
1	Шалгуур 1	Бүрэн хангасан			
2	Шалгуур 2	Бүрэн хангасан			
3	Шалгуур 3	Бүрэн хангасан			
4	Шалгуур 4	Бүрэн хангасан			
5	Шалгуур 5	Бүрэн хангасан			
6	Шалгуур 6	Бүрэн хангасан			
7	Шалгуур 7	Бүрэн хангасан			
Дүгнэлт		БҮРЭН ХАНГАСАН			

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Их Засаг Их Сургуулийн Их Засаг Санхүү Эдийн засаг сургуулийн “НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ” хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг Н.Нямаа
 Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг.....Л.Ариунбат
 Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг.....Ч.Өнөржаргал

ЕРӨНХИЙ ЗӨВЛӨМЖ

1. Зарим мэргэжлийн суурь хичээлүүдийн улирлын шалгалтын тестийн санг баяжуулах, мөн онлайнаар компьютерийн лабораторид шалгалт авах боломжийг бүрдүүлэх.
2. Оюутны бие даах ажлын хүрээнд ашиглах сургалтын материалыг цахим орчинд ашиглах боломжийг бүрдүүлэх.
3. Цаашид багш нар IF-тай сэтгүүлийг онлайнаар ашиглах эрхийг худалдан авах.
4. НББ-ийн хөтөлбөрийн оюутнуудын мэргэжлийн олимпиадын амжилтыг ахиулах
5. Шилжилт хөдөлгөөний журманд хэдэн кредитийг дүйцүүлэн хүлээн зөвшөөрөх заалтыг нэмж оруулах
6. Хөтөлбөрийн хүний нөөцийн цогц бодлогын баримтыг тусгайлан боловсруулах
7. Мэргэшсэн нягтлан бодогч, татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогч, мэргэшсэн үнэлгээчин, аудитор гэх мэт дотоодын болон мэргэжлийн олон улсын зэрэгтэй багшийн тоог нэмэгдүүлэх
8. Багш нарын цалинг бодит цагийн хөлсөөр тооцож олгож буй тогтолцоог бусад сургуулиудтай харьцуулан судлах, хичээлийн кредит цагийн агуулгад багтсан ажлуудыг үнэлэх замаар цалин хөлсийг тодорхойлдог болох.
9. Багшийн ажлын гүйцэтгэлд лекц ба семинарын хичээлийг ижил цагаар тооцож байгааг цаашдаа судлан анхаарах.
10. НББ-ийн хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нар гадаадын болон улсын хэмжээний төсөл, хөтөлбөрт ажиллах
11. Багш нар олон улсын болон дотоодын ЭШ-ны хуралд түлхүү оролцох, гадаадын нэр хүнд бүхий ЭШ-ны сэтгүүлд өгүүлэл нийтлүүлэх, бүтээлийн эшлэгдсэн тоог өсгөх
12. Багшийн сэтгэл ханамжийн судалгааг хийж ажлын ачаалал, цаашид багш нарт зориулсан үйл ажиллагаанд тусгах
13. Цаашид ACBSP магадлан итгэмжлэлд орох зорилт тавьж ажиллах.

IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

№	Нэр	Албан тушаал	Зэрэг цол	Ажилласан жил	Заадаг хичээл

II. Оюутны нэрс

№	Оюутны нэрс	Курс	Сонгосон байдал
			Орон нутгийн, гадаад, Дотуур байранд амьдардаг гэх мэт

III. Ажил олгогчдын нэрс

№	Овог нэрс	Байгууллага	Албан тушаал

IV. Төгсөгчдийн нэрс

№	Овог нэрс	Төгссөн он	Байгууллага	Албан тушаал

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

/албан бичгийг оруулах/

VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан (огноо)

[Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж /Recommendations/

VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан (огноо)

[Магадлан итгэмжлэх комиссын хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж /Recommendations/